



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
Сүхбаатар аймаг дахь төрийн
аудитын газар

НИЙЦЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ТӨСВИЙН САНХҮҮЖИЛТ, ЗАРЦУУЛАЛТЫН ЭРХ ОЛГОЛТ НЬ БАТЛАГДСАН
ТӨСӨВ, ХУВААРЬТ ТУЛГУУРЛАН ХЭРЭГЖСЭН БОЛОВЧ САНХҮҮЖИЛТИЙГ
ХУГАЦААНД НЬ БҮРЭН ОЛГООГҮЙ, ЗАРЦУУЛАХ ЭРХИЙГ ОЛГООГҮЙГЭЭС
ШАЛТГААЛАН ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭ ХОЙШИЛЖ, ӨР ТӨЛБӨР НЭМЭГДСЭН
БАЙНА.

“Төрийн сангийн тогтолцоо, хууль тогтоомжийн нийцэл ”

АУДИТЫН КОД: НАГ-2026/14-ШТА-НА

Баруун-Урт 2026 он

Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор Г.Даваа

Утас: 70518396 Цахим хаяг: davaag@audit.gov.mn
Аудитын менежер М.Нарантуяа

Ахлах аудитор С.Ариунбаяр

Утас: 70512123, Цахим хаяг: Ariunbayars@audit.gov.mn

Аудитор: Б.Ариунзул Цахим хаяг: Arzulb@audit.gov.mn

Аудитор: А.Мөнхцэцэг Цахим
хаяг: Munkhtsetsega@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дараах
хаягаар авна уу. Цахим хуудас: www.audit.mn



СҮХБААТАР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН ТУШААЛ

2026 оны 05 сарын 27 өдөр

Дугаар 8/49

Баруун-Урт сум

Нийцлийн аудитын тайланг
баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1 дэх хэсэг, 20 дугаар зүйлийн 20.1, 20.4 дэх хэсэг, 29 дүгээр зүйлийн 29.4 дэх хэсэг, Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн А/106 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”-ын 18 дугаар зүйлийн 18.9 дэх хэсэг, Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2025 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн “Эрх шилжүүлэх тухай” А/175 дугаар тушаалын 3 дугаар хавсралтын 3 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Төрийн сангийн тогтолцоо, хууль тогтоомжийн нийцэл”-д хийсэн нийцлийн аудитын тайланг нэгдүгээр, аудитын шалгалтаар илрүүлсэн зөрчилтэй холбоотой, зөрчил арилгуулах албан шаардлагыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталгаажуулсугай.

2. Аудитын тайланг Үндэсний аудитын газрын Нийцлийн аудитын газар, аймгийн Санхүү, төрийн сангийн хэлтэс, сумын санхүүгийн албанд хүргүүлж ажиллахыг ахлах аудитор (С.Ариунбаяр)-д үүрэг болгосугай.

3. Аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг 2026 оны 06 дугаар сарын 28, биелэлтийг 2025 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн дотор тус тус Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг аймгийн Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (Д.Ариунжаргал), сумын санхүүгийн албаны дарга нарт хариуцуулсугай.

4. Аудитын тайланг баталгаажуулснаас хойш 21 хоногт багтаан аудитын ажлын болон нотлох баримтыг архивын нэгж болгон архивд хүлээлгэн өгөхийг ахлах аудитор (С.Ариунбаяр), аудитор (А.Мөнхцэцэг), аудитор (Б.Ариунзул) нарт үүрэг болгосугай.

5. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж, холбогдох арга хэмжээ авч ажиллахыг аудитын менежер (М.Нарантуяа)-д даалгасугай.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Г.ДАВАА

D:\Бичиг хэрэг\2025\Тушаал\1. А тушаал-3 2025 хянуулах.docx

222601016

Товчилсон үгийн тайлбар.....	4
Хүснэгтийн товъёг.....	4
Дүрслэлийн товъёг.....	4
Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл	5
БҮЛЭГ 1 Төрийн сангийн тогтолцоо хууль, эрх зүйн шаардлагад нийцэж байгаа ч бүтэц, чиг үүрэг, хүний нөөц, мэдээллийн аюулгүй байдлын чиглэлээр сайжруулах хэрэгцээ байна.....	6
1.1.2. Төрийн сангийн үйл ажиллагааны эрх зүйн зохицуулалт Төсвийн тухай хуультай нийцэж байгаа боловч журмын зарим заалт тодорхой бус байгаа нь хэрэгжилтийн нэгдмэл байдал, хяналт, хариуцлагыг сайжруулах шаардлагыг бий болгож байна.	6
1.2.1 Төрийн сангийн тогтолцоо, зохион байгуулалт хууль, эрх зүйн шаардлагад нийцэж байгаа ч бодлого, стратегийн уялдаа, хүний нөөцийн төлөвлөлт, чадавхыг сайжруулах шаардлагатай байна.....	7
1.2.3 Төрийн сангийн цахим систем өдөр тутмын хэрэгцээг хангаж байгаа бөгөөд мэдээллийн аюулгүй байдлын мэдлэг, хэрэглэгчийн сургалт, арга зүйн дэмжлэгийг нэмэгдүүлэх шаардлагатай байна.....	12
Бүлэг 2 Төрийн сангийн үйл ажиллагаа хууль тогтоомжийн хүрээнд хэрэгжсэн ч санхүүжилт олголт, анхан шатны баримтын бүрдэл, эдийн засгийн ангиллын хяналт, дотоод хяналтын хэрэгжилтийг сайжруулах шаардлагатай байна.	13
2.1 Төсвийн санхүүжилт, зарцуулалтын эрх олголт нь батлагдсан төсөв, хуваарьт тулгуурлан хэрэгжсэн боловч санхүүжилтийг хугацаанд нь бүрэн олгоогүй, зарцуулах эрхийг олгоогүйгээс шалтгаалан төсөл, арга хэмжээ хойшилж, өр төлбөр нэмэгдсэн байна.....	13
2.1.1 Орон нутгийн төсвийн байгууллагуудын санхүүжилтийн эрхийг журамд заасан хугацаа, хуваарийн дагуу тогтмол олгоогүйгээс төлөвлөлт, гүйцэтгэлийн уялдаа алдагдах эрсдэлтэй байна.	13
2.1.2. Санхүүжүүлэх эрх олгоогүйгээс шалтгаалан төсөл арга хэмжээ хойшилж, өр төлбөр нэмэгдсэн байна 15	
2.2.1 Орон нутгийн төрийн сангийн дансны үлдэгдлийг Сангийн яам болон Монгол банкны үлдэгдэлтэй тулган баталгаажуулж, санхүүгийн тайланд тусган аудитаар баталгаажуулсан нь холбогдох журмын дагуу хэрэгжсэн байна.....	17
2.2.2 Төрийн сангийн төлбөр, тооцооны гүйлгээг анхан шатны баримтын бүрдэл хангалтгүй, эдийн засгийн ангиллын дагуу хянаж баталгаажуулахгүйгээр гүйцэтгэсэн нь дотоод хяналт, төсвийн сахилга бат, хариуцлагын тогтолцоог сулруулах эрсдэлтэй байна.....	18
2.2.3. Төрийн сангийн гүйлгээний буцаалт, амжилтгүй гүйлгээ нь төсвийн багцын хүрэлцээгүй байдал, мэдээлэл-баримтын бүрдүүлэлт болон бүртгэлийн хяналтаас голлон шалтгаалж байна.....	21
2.2.4 Төсвийн гүйцэтгэлийн мэдээг хугацаанд нь хүлээн авч баталгаажуулж байгаа ч мэдээллийг бүрэн цахимжуулж, систем хоорондын уялдаа, өгөгдөл солилцоог сайжруулах хэрэгцээ үүссэн байна.	23
2.3 Дотоод болон хөндлөнгийн хяналтын тогтолцоо хэрэгжиж байгаа хэдий ч эрсдэлийн үнэлгээ, өдөр тутмын хяналт, хяналтын мөрөөр авах арга хэмжээний үр нөлөө хангалтгүй байвал зөрчил давтагдах, төлбөр тооцооны сахилга бат сулрах, төрийн сангийн үйл ажиллагааны найдвартай байдалд сөргөөр нөлөөлөх эрсдэлтэй байна.	23
2.3.1 Төв төрийн сангаас аймгийн төрийн санд дотоод хяналт хэрэгжүүлээгүй, дотоод хяналтаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтэд тавих хяналт, хариуцлагын механизм сул байгаагаас алдаа, зөрчил давтан гарч байна. 24	
2.3.2. Төрийн сангийн өдөр тутмын дотоод хяналтыг үр дүнтэй хэрэгжүүлээгүйгээс төлбөр тооцооны архивын нэгжийг үүсгэх ажил хангалтгүй байна.	25
2.3.3 Өмнөх аудитын хэрэгжилтийг бүрэн хангагджээ.....	27
ДҮГНЭЛТ:.....	30
ЗӨВЛӨМЖ:.....	30
Үндэсний аудитын газраар уламжлуулах санал:.....	31

Товчилсон үгийн тайлбар

АДБОУБ	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Байгууллага
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ЕОД	Ерөнхий орлогын данс
ЖМС	Жижиг мөнгөн сан
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
НББ	Нягтлан бодох бүртгэл
НБББХ	Нягтлан бодох бүртгэлийн бодлого хариуцсан
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
СТСХ	Санхүү, төрийн сангийн хэлтэс
ТАЗ	Төрийн Албаны Зөвлөл
ТБОНӨХБАҮХАТХ	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ТСУЦС	Төрийн сангийн удирдлагын цахим систем
ХАБЭАХ	Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйг хангах
ХХС	Хоршоо хөгжүүлэх сан

Хүснэгтийн товчёр

№	Тайлбар	Хуудасны дугаар
1	СТСХ-ийн албан хаагчдын албан тушаалын тодорхойлолт баталсан байдал	7
2	Сумын төрийн сангийн албан хаагчдын албан тушаалын тодорхойлолтын нийцээгүй байдлын судалгаа	8-9
3	2023-2025 онд сумдад олгосон санхүүгийн дэмжлэгийн судалгаа	13
4	Зарцуулах эрх илүү олгосон судалгаа	13
5	Ерөнхий орлогын дансны үлдэгдлийн судалгаа	16
6	Төрийн сангийн гүйлгээний судалгаа	17
7	Эдийн засгийн ангиллын дагуу зарцуулаагүй зардлын судалгаа	18
8	Хоол үйлдвэрлэлийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгжид мөнгөн хөрөнгө шилжүүлсэн судалгаа	19
9	Буцсан гүйлгээний судалгаа	20
10	Амжилтгүй гүйлгээний судалгаа	20
11	Зөвлөмжийн хэрэгжилтийн судалгаа	25-26

Дүрслэлийн товчёр

№	Тайлбар	Хуудасны дугаар
1	Цахим системийн хүндрэл, бэрхшээлийн судалгаа	11
2	Дансны үлдэгдлийн судалгаа	15

	Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл
Аудит хийх үндэслэл, бүрэн эрх	Аудитыг Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Монгол Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны 2025 оны “Аудитын сэдэв батлах тухай” 25 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторовын “Төрийн аудитын байгууллагын 2026 онд гүйцэтгэх аудитын жилийн төлөвлөгөө”-г үндэслэн гүйцэтгэв.
Аудитын зорилт	Төрийн сангийн тогтолцоо, хууль тогтоомжийн хэрэгжилтэд нийцлийн аудит хийж, дүгнэлт, зөвлөмж боловсруулан дүнг аймгийн ИТХ, Засаг дарга болон холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулж, олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилт чиглэгдсэн.
Аудитын хамарсан хүрээ	Аудитыг төрийн сангийн тогтолцоо, үйл ажиллагааг тодорхойлсон бодлого, хууль тогтоомжийн нийцэл, төсвийн ерөнхийлөн захирагч, Санхүү, төрийн сангийн хэлтэс, төрийн байгууллага, Төрийн сангийн удирдлагын цахим системийн 2023-2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөө, тайлан, бүтцийн зохион байгуулалт, чиг үүрэг оновчлол, хэрэгжүүлж буй арга хэмжээний үр дүн, үр нөлөөнд үнэлгээ хийв.
Аудитын арга зүй, шалгуур үзүүлэлт	Аудитыг АДБОУБ (INTOSAI)-ын Стандартын хорооноос баталсан АДБОУС-100, АДБОУС-300, АДБОУС-3000-д нийцүүлсэн Монгол Улсын Төрийн аудитын стандарт MNS 6817-1:2020 “Төрийн аудит. Тулгуур зарчим”, MNS 6817-6:2020 “Төрийн аудит. Нийцлийн аудитын зарчим”, MNS 6817-8:2020 “Төрийн аудит. Нийцлийн аудит”-ын стандартад заасан зарчим, арга зүйд нийцүүлэн, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам, түүнд нэмэлт өөрчлөлт оруулсан Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2021 оны А/71 дүгээр тушаалаар баталсан “Нийцлийн аудитын заавар, аргачлал”-ыг ашиглан холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга лавлагаа, тодруулга болон судалгаа авах, харьцуулах, нэгтгэх, дүн шинжилгээ, түүвэрлэлт хийх зэрэг судалгааны арга зүйг ашиглан аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж боловсруулав.
Аудитын бүрэлдэхүүн, хугацаа	Аудитын дэд төлөвлөгөөг 2026 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн дотор батлуулан нээлт хийж, талбарын ажлыг 03 дугаар сарын 26-ны өдрөөс 5 дугаар сарын 10-ны өдрийг хүртэл гүйцэтгэж, тайланг 05 дугаар сарын 20-ны өдрийн дотор боловсруулж, үе шатны хяналтыг хийлгэн, Тэргүүлэх аудиторовын тушаалаар баталгаажуулж, холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлэв.

БҮЛЭГ 1 Төрийн сангийн тогтолцоо хууль, эрх зүйн шаардлагад нийцэж байгаа ч бүтэц, чиг үүрэг, хүний нөөц, мэдээллийн аюулгүй байдлын чиглэлээр сайжруулах хэрэгцээ байна.

1.1.2. Төрийн сангийн үйл ажиллагааны эрх зүйн зохицуулалт Төсвийн тухай хуультай нийцэж байгаа боловч журмын зарим заалт тодорхой бус байгаа нь хэрэгжилтийн нэгдмэл байдал, хяналт, хариуцлагыг сайжруулах шаардлагыг бий болгож байна.

1.1.2.1 Төсвийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.2 дахь хэсэгт “Төрийн сангийн үйл ажиллагааны журмыг Засгийн газар батална.” гэж заасны дагуу Засгийн газрын 2023 оны 444 дүгээр тогтоолоор “Төрийн сангийн үйл ажиллагааны журам”-ыг шинэчлэн баталсан байна.

1.1.2.2 Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 444 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн сангийн үйл ажиллагааны журам”-д орон нутгийн төрийн сан зарим зардлыг санхүүжүүлэхдээ холбогдох шийдвэр, гэрээ, ажлын тайлан, гүйцэтгэлийг нотлох баримтад үндэслэн санхүүжилт олгохоор зохицуулсан байна. Гэвч журмын 2.6.3 дахь заалтад байхгүй заалт болох “2.6.10–2.6.14”-ийг иш татсан нь ямар төрлийн зардлыг уг зохицуулалтад хамруулахыг тодорхойгүй болгож байна. Үүнээс шалтгаалан орон нутгийн төрийн сангууд уг заалтыг нэг мөр ойлгож, ижил байдлаар хэрэгжүүлэхэд хүндрэл үүсэх эрсдэлтэй байна.

1.1.2.3 Журмын 2.6.3 дахь заалтад байхгүй заалтыг иш татсан нь тухайн зохицуулалтаар ямар төрлийн зардлыг, ямар баримт бичигт үндэслэн, ямар хяналтын дарааллаар санхүүжүүлэхийг тодорхойгүй болгож байна. Үүний улмаас аймаг, нийслэл, сум, дүүргийн төрийн сангууд уг заалтыг нэг мөр ойлгож хэрэглэхэд хүндрэл үүсэх, санхүүжилт олгох үйл ажиллагаанд ялгаатай практик бий болох, хяналт, хариуцлагын зохицуулалт сулрах эрсдэлтэй байна. Цаашлаад зардлын санхүүжилтийг хууль, журамд бүрэн нийцүүлэн гүйцэтгэхэд тодорхой бус байдал үүсэж, төсвийн хөрөнгийн зарцуулалт, гүйцэтгэл, тайлагналд алдаа, зөрчил гарах нөхцөл бүрдэж болзошгүй байна.

1.1.2.4 Улсын Их Хурлаас Төсвийн тухай хуулийг шинэчлэн найруулж баталсантай холбогдуулан Монгол Улсын Засгийн газрын 2013 оны 116 дугаар тогтоолоор “Төрийн сангийн зарим чиг үүргийг хэрэгжүүлж эхлэх тухай” зохицуулалтыг баталсан байна. Уг тогтоолоор хөрөнгө оруулалтын асуудал хариуцсан нэгжийн зарим чиг үүргийг төрийн сангийн үйл ажиллагаанд хамааруулан хэрэгжүүлэхээр зохицуулжээ.

1.1.2.5 Мөн Монгол Улсын Засгийн газрын 2014 оны 326 дугаар тогтоолоор баталсан “Санхүүгийн алба байгуулах тухай” тогтоолын хавсралтад сумын санхүүгийн албаны зохион байгуулалт, чиг үүрэг, орон тооны жишиг нормативыг тогтоосон байна. Үүний дагуу сумдын санхүүгийн алба төрийн сангийн үйл ажиллагааг хэрэгжүүлж байгаа бөгөөд төрийн сангийн үйл ажиллагааг зохицуулж буй нийтээр мөрдөх эрх зүйн актууд нь Төсвийн тухай хуулийн зохицуулалттай нийцэж байна.

1.2 Төрийн сангийн бүтэц хууль, эрх зүйн шаардлагад нийцэж байгаа бөгөөд албан тушаалын чиг үүргийг тодорхой болгох, ажлын ачааллыг тэнцвэржүүлэх, мэдээллийн аюулгүй байдлын чадавхыг нэмэгдүүлэх шаардлагатай байна.

1.2.1 Төрийн сангийн тогтолцоо, зохион байгуулалт хууль, эрх зүйн шаардлагад нийцэж байгаа ч бодлого, стратегийн уялдаа, хүний нөөцийн төлөвлөлт, чадавхыг сайжруулах шаардлагатай байна.

1.2.1.1 Төсвийн тухай хуулийн 36 дугаар зүйлд төрийн сангийн тогтолцоо, зохион байгуулалтын хэлбэрийг тодорхойлж, 36 дугаар зүйлийн 36.1¹-т төрийн сангийн тогтолцооны бүрэлдэхүүн, 36.2² дахь хэсэгт зохион байгуулалтын хэлбэрийг тус тус зохицуулсан байна.

1.2.1.2 Засгийн газраас төрийн сангийн үйл ажиллагаатай холбоотой бодлого стратеги баталж хэрэгжүүлээгүй, харин Засгийн газрын 2022 оны 76 дугаар тогтоолоор Сангийн яамны үйл ажиллагааны стратеги, бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр баталсан боловч 2025 онд хүчингүй болгосон байна.

1.2.1.3 Аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн бүтэц, орон тоог Сангийн сайдын 2015 оны 90 дүгээр тушаалаар баталсан зааварт нийцүүлэн 8 орон тоотойгоор баталсан байна. Тус хэлтэс 2025 оны байдлаар 7 орон тоотой ажиллаж, төрийн сангийн чиг үүргийг хэрэгжүүлж байна. Орон тоо дутуу байгаа нь батлагдсан бүтцэд төсвийн орлого бүрдүүлэлт хариуцсан мэргэжилтний орон тоог шинээр нэмсэн ч санхүү, эдийн засгийн нөхцөл байдлаас шалтгаалан уг ажлын байрны сонгон шалгаруулалтыг зарлаагүйтэй холбоотой байна.

1.2.1.4 Сумын төрийн санд батлагдсан 27 орон тооноос 23 албан хаагч ажиллаж байгаа бөгөөд Баруун-Урт, Наран, Уулбаян, Эрдэнэцагаан сумын төсөв, төрийн сангийн мэргэжилтний орон тоо сул байна. Энэ нь ажлын байрны сонгон шалгаруулалтад шаардлага хангасан иргэний материал ирдэггүй, алслагдсан суманд ажиллах сонирхол бага, мэргэжлийн боловсон хүчний нөөц хүрэлцээгүйтэй холбоотой байна.

1.2.1.5 Харин сумын төрийн сангийн үйл ажиллагааг Засгийн газрын 2014 оны “Санхүүгийн алба байгуулах тухай” 326 дугаар тогтоолоор албаны дарга, төрийн сангийн мэргэжилтэн, төсвийн нягтлан бодогч, татварын байцаагч гэсэн 5 орон тоотой байхаар баталсны дагуу Баруун-Уртаас бусад сум тогтоолын дагуу санхүүгийн албыг байгуулсан байна.

1.2.1.6 Засгийн газрын тогтоолын хавсралтаар баталсан чиг үүрэг, орон тооны жишиг нормативын 1.4.2-т “татварын байцаагч нь татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад харьяалагдах бөгөөд санхүүгийн албаны даргын шуурхай удирдлагад ажиллана” гэж зохицуулсан байна. Гэвч татварын байцаагчийн харьяалал, удирдлагын тогтолцоо нь өөр байгууллагын бүтцэд хамаарч байгаа тул санхүүгийн албаны даргын шууд удирдлагад ажиллах нөхцөл бодит байдал дээр бүрдээгүй байна.

¹ Төрийн сангийн тогтолцоо нь төв төрийн сан, аймаг, нийслэл, улсын зэрэглэлтэй хотын төрийн сан, сум, дүүрэг, орон нутгийн зэрэглэлтэй хот, тосгоны төрийн сан, төрийн захиргааны төв байгууллагын төрийн сангийн нэгж, төсвийн нягтлан бодогч /цаашид "төрийн сан" гэх/-оос бүрдэнэ.

² Төв төрийн сан нь санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад, аймаг, нийслэл, сум, дүүргийн төрийн сан нь тухайн шатны Засаг даргын Тамгын газрын дэргэд, улсын болон орон нутгийн зэрэглэлтэй хот, тосгоны төрийн сан нь тухайн шатны Захирагчийн ажлын албаны дэргэд байна.

1.2.1.7 Харин Баруун-Урт сумын санхүүгийн албыг Засгийн газрын 2015 оны 426 дугаар тогтоолын нэмэлт, өөрчлөлтийн дагуу 3 орон тоотойгоор үйл ажиллагааны чиг үүргийг хэрэгжүүлэхээр сумын Засаг даргын 2016 оны “Санхүүгийн алба байгуулах тухай” А/48 дугаар захирамжаар байгуулсан байна. Гэвч 426 дугаар тогтоолын нэмэлт, өөрчлөлтийг Засгийн газрын 2019 оны 88 дугаар тогтоолоор хүчингүй болсонд тооцсон боловч сумын Засаг дарга санхүүгийн албаны бүтэц, орон тоо, чиг үүргийг шинэчлэн батлах шийдвэрийг одоог хүртэл гаргаагүй байна.

1.2.1.8 Тус сумын санхүүгийн албаны бүтэцэд “хөрөнгө оруулалт хариуцсан” чиг үүргийг хэрэгжүүлэх мэргэжилтний орон тоог баталсан нь Засгийн газрын 2014 оны “Санхүүгийн алба байгуулах тухай” 326 дугаар тогтоолын хавсралтаар баталсан жишигтэй нийцээгүй байна. Иймд санхүүгийн албаны бүтэц орон тоо, чиг үүргийг Засгийн газрын тогтоолд нийцүүлэн шинэчлэн зохион байгуулах шаардлага үүссэн байна.

1.2.1.9 Аймаг, сумын төрийн сан нь тухайн шатны Засаг даргын Тамгын газрын дэргэд ажиллаж, төсвийн захирагчийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн мэдээ болон холбогдох бусад тайлан, мэдээллийг хууль, журамд нийцүүлэн Сангийн яаманд хүргүүлэх чиг үүргийг хэрэгжүүлж байгаа нь төрийн сангийн тогтолцоо хууль эрх зүйн орчин, бүтэц зохион байгуулалтын хувьд нийцэж байгааг харуулж байна.

1.2.2 Төрийн сангийн албан хаагчдын албан тушаалын тодорхойлолтод чиг үүргийн давхардал, хууль эрх зүйн нийцлийн зөрчил үүссэн, ажлын ачаалал харилцан адилгүй байна

1.2.2.1 Засгийн газрын 2014 оны “Санхүүгийн алба байгуулах тухай” 326 дугаар тогтоолоор төрийн сангийн албан хаагчийн чиг үүргийг, Сангийн сайдын 2015 оны “Заавар батлах тухай” 90 дүгээр тушаалаар орон нутгийн санхүү, төрийн сангийн ажилтны ажил чиг үүргийн жишиг зааврыг тус тус баталжээ.

Санхүү төрийн сангийн хэлтсийн албан хаагчдын албан тушаалын тодорхойлолтыг дараах байдлаар баталж, үйл ажиллагааны чиг үүргийг хэрэгжүүлж байна.

Хүснэгт 1. СТСХ-ийн албан хаагчдын албан тушаалын тодорхойлолт баталсан байдал.

д/д	Албан тушаалын нэр	ТАЗ-аас баталсан тогтоол		АЗДТГ-аас баталсан тушаал	
		огноо	дугаар	огноо	дугаар
1	Хэлтсийн дарга	2022.06.15	430	2022.06.30	А/35
2	ТЕЗ-ын ерөнхий нягтлан бодогч	2022.06.15	430	2022.06.30	А/35
3	Төрийн сангийн дотоод хяналтын бодлого, үйл ажиллагааг зохион байгуулах ахлах мэргэжилтэн	2022.06.15	430	2022.06.30	А/35
4	Төсвийн бодлого хариуцсан ахлах мэргэжилтэн	2022.06.15	430	2022.06.30	А/35
5	НББ-ийн бодлого хариуцсан ахлах мэргэжилтэн	2025.12.03	554		
6	Төсвийн орлого бүрдүүлэлт хариуцсан мэргэжилтэн	2025.12.03	554		
7	Төрийн сангийн төлбөр тооцоо хариуцсан мэргэжилтэн	2025.12.03	554		
8	Төрийн сангийн төлбөр тооцоо хариуцсан мэргэжилтэн	2025.12.03	554		

(Эх сурвалж. ЗДТГ-ын хүний нөөц хариуцсан ахлах мэргэжилтэн)

1.2.2.2 Төрийн албаны зөвлөлийн тогтоол болон ЗДТГ-ын даргын А/03 тушаалаар бүтэц, орон тоог шинэчлэн батлахдаа төсвийн орлого бүрдүүлэлт хариуцсан мэргэжилтний орон тоог нэмсэн байна. Энэ орон тоо, чиг үүргийг Сангийн сайдын

2015 оны “Заавар батлах тухай” 90 дүгээр тушаалаар тусгайлан зохицуулсан бөгөөд өмнө нь уг чиг үүргийг төсвийн бодлогын мэргэжилтэн хэрэгжүүлдэг байсан.

1.2.2.3 Аймгийн Засаг даргын 2020 оны “Гарын үсэг зурах эрх олгох тухай” А/602 дугаар захирамжаар өөрийн эрхлэх асуудлын хүрээний орлого, зарлагын дансны ажил гүйлгээнд нэгдүгээр гарын үсэг зурах эрхийг СТСХ-ийн даргад олгосны дагуу ОНХС болон мөрийн хөтөлбөр хэрэгжүүлэх зардал гэх мэт дансны ажил гүйлгээнд гарын үсэг зурж байна.

1.2.2.4 Энэ нь хэлтсийн даргын албан тушаалын тодорхойлолтод тусгагдаагүй чиг үүргийг хэрэгжүүлж байгаа бөгөөд ажил үүргийн зааг ялгаа алдагдах, эрх мэдлийн давхардал үүсэх, хяналт-тэнцлийн зарчим сулрах, улмаар дотоод хяналтын тогтолцоо алдагдах, хариуцлага тооцох нөхцөл тодорхойгүй болох, ашиг сонирхлын зөрчил үүсэх эрсдэлийг нэмэгдүүлж байна.

1.2.2.5 Төрийн албаны зөвлөлийн 2025 оны “Зөвшөөрөл олгох тухай” 208 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар Санхүүгийн албаны дарга (төсвийн ерөнхийлөн нягтлан бодогч)-ийн, 3 дугаар хавсралтаар төсөв, төрийн сангийн мэргэжилтний жишиг албан тушаалын тодорхойлолтыг тус тус баталж хүргүүлсэн бөгөөд уг тодорхойлолтыг байгууллагын эрх бүхий албан тушаалтан баталсан байна.

1.2.2.6 Төрийн албаны зөвлөлөөс баталсан жишиг албан тушаалын тодорхойлолтод туссан чиг үүрэг нь Засгийн газрын 2014 оны 326 дугаар тогтоол болон Сангийн сайдын 2015 оны 90 дүгээр тушаалаар баталсан заавартай нийцэж байна. Харин харьцуулсан дүн шинжилгээний явцад зарим чиг үүргийг хууль, эрх зүйн зохицуулалттай уялдуулах, илүү тодорхой болгох, давхардлыг арилгах шаардлагатай нь тогтоогдлоо. Албан тушаалын тодорхойлолтод хийсэн дүн шинжилгээг дараах байдлаар харуулав.

Хүснэгт.2 Сумын төрийн сангийн албан хаагчдын албан тушаалын тодорхойлолтын нийцээгүй байдлын судалгаа

ТАЗ-ийн баталсан жишиг албан тушаалын тодорхойлолтын			Тайлбар
зорилт	заалт	Хэрэгжүүлэх чиг үүрэг	
1	11	Харьяа байгууллагуудын өр, авлагын болон арилжааны банкны дансны үлдэгдлийн сарын мэдээг нэгтгэн боловсруулах, удирдлагад танилцуулах, дээд шатны байгууллагад хуулийн хугацаанд хүргүүлэх	Төсөв, төрийн сангийн мэргэжилтэнтэй давхацсан. Төрийн сан арилжааны банкин дахь түр дансыг хаасан.
	1	Орон нутгийн төсвийн байгууллагын урамшууллын тооцоог холбогдох журмын дагуу хийх хуваарилах санхүүжилт олгох	Тодорхойгүй чиг үүрэг
	9	Төсөвт байгууллагуудын жижиг мөнгөн сангийн тайлан хянах	Төрийн сан арилжааны банкин дахь түр дансыг хаасан. ЖМС-ийн тайлан гардаггүй.
2	12	Сум хөгжүүлэх сан, орон нутгийн хөгжлийн сангийн санхүүгийн баримтад 2 дугаар гарын үсэг зурж тайлан баланс гаргах	Уг чиг үүргийг тусгайлан нягтлан бодогч хэрэгжүүлж байгаа.
	15	Сумын хэмжээнд ТБОНТХБАҮХАТХ-ийн дагуу худалдан авах ажиллагааг зохион байгуулах	Ашиг сонирхол зөрчил үүсэх эрсдэлтэй байна
3	4	Жендэрийн эрх тэгш байдлын тухай хууль, тогтоол, шийдвэр, бодлогын баримт бичиг болон холбогдох үйл ажиллагааны тайлан мэдээг боловсруулах, нэгтгэн тайлагнах, холбогдох байгууллагад дурдсан хугацаанд хүргүүлэх,	Нийгмийн хөгжлийн бодлогын мэргэжилтний чиг үүрэгтэй давхацсан. Хуулийн нэршил буруу
4	1	ХАБЭАХ тогтоомж, стандартыг хэрэгжүүлэх, өөрийн харьяалах ажлын байр болон үйлдвэрлэлийн орчинд тохирсон дүрэм, журмыг боловсруулахад оролцох, дүрэм журам заавар стандартуудыг мөрдөж ажиллах	Хэт их цар хүрээг хамарсан тул орон нутгийн түвшинд тохирох хэлбэрээр оруулах.
	4	Удирдлагын хуульд нийцсэн үүрэг даалгаврыг шуурхай биелүүлэх эргэн мэдээлэх	энэ 2 чиг үүрэг давхацсан

	7	Удирдлагаас өгсөн хууль ёсны үүрэг даалгаврыг биелүүлэх			
		Төсвийн мэргэжилтэн			
3	1	Харьяа байгууллагуудын өр, авлагын болон арилжааны банкны дансны үлдэгдлийн сарын мэдээг нэгтгэн боловсруулах, удирдлагад танилцуулах, дээд шатны байгууллагад хуулийн хугацаанд хүргүүлэх	Албаны даргын чиг үүрэгтэй давхацсан		
	4	Төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэмжээнд хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих, эрсдэлийн удирдлагаар хангахад чиглэсэн Дотоод аудитыг хэрэгжүүлж дээд шатны байгууллагатай хамтран ажиллах	Санхүүгийн хяналт, дотоод аудитын газрын хэрэгжүүлэх чиг үүрэг		
5	2	ХАБЭАХ тогтоомж, стандартыг хэрэгжүүлэх, өөрийн харьяалах ажлын байр болон үйлдвэрлэлийн орчинд тохирсон дүрэм, журмыг боловсруулахад оролцох, дүрэм журам заавар стандартуудыг мөрдөж ажиллах	Хэт их цар хүрээг хамарсан тул орон нутгийн түвшинд тохирох хэлбэрээр оруулах.		
	5	Удирдлагын хуульд нийцсэн үүрэг даалгаврыг шуурхай биелүүлэх эргэн мэдээлэх	энэ 2 чиг үүрэг давхацсан		
	8	Удирдлагаас өгсөн хууль ёсны үүрэг даалгаврыг биелүүлэх			

(Эх сурвалж: Төрийн албан зөвлөлийн 208 дугаар тогтоол)

1.2.2.7 Сангийн сайдын 2015 оны “Заавар батлах тухай” 90 дүгээр тушаалын хавсралтаар баталсан зааварт сумын санхүүгийн албаны дарга 26, төсөв, төрийн сангийн мэргэжилтэн 15 чиг үүрэг хэрэгжүүлэхээр тусгасан байна. Харин Төрийн албаны зөвлөлийн жишиг албан тушаалын тодорхойлолтод санхүүгийн албаны дарга 46, төсөв, төрийн сангийн мэргэжилтэн 23 чиг үүрэг хэрэгжүүлэхээр тусжээ.

1.2.2.8 Чиг үүргийн тоо нэмэгдсэн нь зөвхөн төсөв, төрийн сангийн үндсэн ажилтай холбоотой бус, төрийн албан хаагчийн нийтлэг үүрэг, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, архив, албан хэрэг хөтлөлт зэрэг бусад хуульд заасан үүргийг албан тушаалын тодорхойлолтод нэмж тусгасантай холбоотой байна.

1.2.2.9 Албан тушаалын тодорхойлолтод санхүүгийн албаны дарга “Сумын хэмжээнд ТБОНӨХБАҮХАТХ-ийн дагуу худалдан авах ажиллагааг зохион байгуулах” хэрэгжүүлэхээр тусгасан нь төсөл арга хэмжээг гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах, төлбөр тооцоог хянаж, батлах чиг үүргийг хэрэгжүүлэхээр байгаа нь ашиг сонирхлын зөрчил үүсэх эрсдэл өндөр байна.

1.2.2.10 Учир нь санхүү албаны дарга нь худалдан авах ажиллагааны шийдвэр гаргах, мөн санхүүгийн гүйлгээг баталгаажуулах хоёр чиг үүргийг зэрэг хэрэгжүүлснээр хяналт, тэнцвэрийн зарчим болон Төрийн албаны тухай хууль болон холбогдох хуульд заасан төрийн албаны ил тод, итгэл даах байдлыг хангах зорилт алдагдах сөрөг үр дагавар гарахыг анхаарч үзэх нь зүйтэй байна.

1.2.2.11 Иймд Төрийн албаны зөвлөлийн 2025 оны “Зөвшөөрөл олгох тухай” 208 дугаар тогтоолоор батлагдсан сумын төрийн захиргааны албан хаагчдын албан тушаалын тодорхойлолтод өөрчлөлт оруулж, хууль тогтоомжид нийцүүлэх шаардлага үүссэн байна.

1.2.2.12 Төрийн сангийн гүйлгээний тоонд үндэслэн төсөв, төрийн сангийн мэргэжилтний ажлын ачаалалд дүн шинжилгээ хийхэд аймгийн болон Баруун-Урт сумын төрийн сангийн төсвийн мэргэжилтний ачаалал, бусад алслагдсан сумын төрийн сантай харьцуулалт хэт өндөр үзүүлэлттэй гарч байна. Тухайлбал:

- Хөдөөгийн алслагдсан сумын төрийн санд өдөрт дунджаар (нэг жилд 240 ажлын өдөр байхаар тооцсон) 14.4 орлого зарлагын гүйлгээг хийж хянаж байгаа бол Баруун-Урт сумын төрийн сангийн мэргэжилтэн 45.6 буюу 3.2 дахин, аймгийн төрийн сангийн мэргэжилтэн 60.8 буюу 4.2 дахин их гүйлгээг хянаж баталгаажуулж байна.

1.2.2.13 Баруун-Урт сумын Санхүүгийн албаны дарга Орон нутгийн хөгжлийн сан болон ХХС-ийн ажил гүйлгээнд хоёрдугаар гарын үсэг зурж, санхүүгийн тайланг бэлтгэн, Төрийн сангийн системд хянан баталгаажуулж байгаа нь Засгийн газрын 2014 оны 326 дугаар тогтоолын хавсралтын 1.1.5, 2.1 дэх хэсэгт заасан чиг үүргийн зохицуулалттай нийцэхгүй байна.

1.2.2.14 Санхүүгийн албаны дарга хөрөнгө оруулалт, төсөл, арга хэмжээ болон тусгай сангийн ажил гүйлгээг гүйцэтгэхийн зэрэгцээ түүнийг хянан баталгаажуулж байгаа нь ажил үүргийн зааг ялгааг алдагдуулж, хяналт-тэнцлийн зарчим сулрах эрсдэлийг нэмэгдүүлж байна. Үүний улмаас төсвийн хөрөнгийн зарцуулалтад тавих дотоод хяналтын үр нөлөө буурах, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх шаардлага хангагдахгүй байх сөрөг үр дагавар үүсэж болзошгүй байна.

1.2.2.15 Иймд ОНХС, ХХС зэрэг тусгай сангийн нягтлан бодох бүртгэл, ажил гүйлгээг холбогдох нягтлан бодогчид хариуцуулж, Санхүүгийн албаны даргын хянан баталгаажуулах чиг үүргийг ажил үүргийн хуваарь, албан тушаалын тодорхойлолттой уялдуулах шаардлагатай байна.

1.2.2.16 Төрийн сангийн чиг үүргийг хэрэгжүүлж буй албан хаагчдын бүтэц, чиг үүргийн судалгаагаар зарим албан хаагч үндсэн чиг үүргээс гадна Санхүүгийн зохицуулах хорооны орон нутгийн төлөөлөгч болон улсын дайчилгааны төлөвлөлттэй холбоотой үүргийг хавсран хэрэгжүүлж байна. Энэ нь байгууллагын хүний нөөцийг олон чиг үүрэгт ашиглаж байгааг харуулахын зэрэгцээ ажлын ачаалал, чиг үүргийн давхардлыг цаашид үнэлэх шаардлагатайг илтгэж байна.

1.2.2.17 Албан хаагчдын ажилласан жилийн бүтцээс харахад 69.9 хувь нь тухайн албан тушаалдаа 3-аас дээш жил ажилласан байгаа нь төрийн сангийн чиг үүргийг хэрэгжүүлэгч хүний нөөц харьцангуй тогтвортой байгааг харуулж байна. Харин 30.0 хувь нь 3 хүртэл жил ажилласан нь шинээр томилогдсон болон туршлага хуримтлуулах шатанд байгаа албан хаагчдад чиглэсэн мэргэшүүлэх сургалт, дадлагажуулах арга хэмжээг үргэлжлүүлэх хэрэгцээ, шаардлага байгааг илтгэж байна.

1.2.2.18 Ийм тогтвортой байдлыг хангахад Төрийн албаны тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.3³-т заасан таван жил тутамд зургаан сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний мөнгөн урамшуулал олгох, мөн 57 дугаар зүйлийн 57.17⁴-д заасан орон нутгийн нэмэгдэл олгох зохицуулалтын хэрэгжилт эергээр нөлөөлсөн байна.

1.2.2.19 Дээрх зохицуулалт нь төрийн албаны тогтвортой, тасралтгүй, мэргэшсэн байх зарчмыг хангах, төрийн албан хаагчдыг орон нутагт тогтвор суурьшилтай ажиллахад дэмжлэг үзүүлэх, хүний нөөцийн эргэлт хөдөлгөөнийг бууруулах нөхцөлийг бүрдүүлж байна.

1.2.2.20 Сумын санхүүгийн албаны нягтлан бодогч нь Соёлын төвийн нягтлан бодогчийн албан үүргийг хавсран гүйцэтгэж байгаа бөгөөд Соёлын төвийн бүтцэд нягтлан бодогчийн орон тоо 0.5 байхаар батлагдаж байгаатай холбоотой байна.

³ Сум болон нийслэлийн Багахангай, Багануур, Налайх дүүрэгт тасралтгүй ажиллаж байгаа төрийн захиргааны албан хаагчид таван жил тутамд нэг удаа зургаан сарын үндсэн цалинтай нь тэнцэх хэмжээний мөнгөн урамшууллыг олгох бөгөөд мөнгөн урамшуулал олгох журмыг Засгийн газар батална.

⁴ Захиргааны, үйлчилгээний болон улс төрийн албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчид орон нутгийн нэмэгдэл олгож болно.

1.2.2.21 Дээр дурдсан нөхцөл байдал болон судалгааны дүнгээс үзэхэд төрийн сангийн чиг үүргийг хэрэгжүүлж буй албан хаагчдын албан тушаалын тодорхойлолтод бусад албан тушаалтны чиг үүрэгтэй давхцах, ижил төстэй байдлаар тусгагдсан чиг үүрэг байна. Мөн зарим чиг үүрэг нь холбогдох хууль тогтоомж, эрх зүйн актын зохицуулалттай бүрэн уялдаагүй, албан хаагчдын ажлын ачаалал харилцан адилгүй хуваарилагдсан байна.

1.2.2.22 Энэ нь албан тушаалын тодорхойлолтыг байгууллагын бодит чиг үүрэг, хууль, эрх зүйн шинэчлэл, ажлын ачааллын бодит нөхцөлтэй бүрэн уялдуулан шинэчлээгүйтэй холбоотой байна. Үүний улмаас ажил үүргийн зааг ялгаа тодорхойгүй болох хариуцлагын хүрээ, дотоод хяналт болон хяналт-тэнцлийн зарчим сулрах эрсдэл үүсэж байна.

1.2.2.23 Цаашид уг нөхцөл байдал нь төрийн сангийн үйл ажиллагааны үр ашиг буурах, шийдвэр гаргалт болон хянан баталгаажуулалтын явцад эрх мэдэл давхардах, ашиг сонирхлын зөрчил үүсэх, хариуцлага тооцоход хүндрэл бий болгох сөрөг үр дагавартай байна. Иймд төрийн сангийн чиг үүргийг хэрэгжүүлж буй албан хаагчдын албан тушаалын тодорхойлолтыг холбогдох хууль, журам, бодит ажлын ачаалал, дотоод хяналтын шаардлагатай уялдуулан шинэчилж, чиг үүргийн давхардлыг арилгах, хариуцлагын зааг ялгааг тодорхой болгох шаардлагатай байна.

1.2.3 Төрийн сангийн цахим систем өдөр тутмын хэрэгцээг хангаж байгаа бөгөөд мэдээллийн аюулгүй байдлын мэдлэг, хэрэглэгчийн сургалт, арга зүйн дэмжлэгийг нэмэгдүүлэх шаардлагатай байна.

1.2.3.1 Засгийн газрын санхүүгийн удирдлагын мэдээллийн системд мөрдөх зааврыг Сангийн сайдын 2024 оны 256 дугаар тушаалаар шинэчлэн баталж, төрийн сангийн гүйлгээний төлбөр, тооцооны мэдээллийг цахимаар бүртгэх, хянах, баталгаажуулах PORTOL программыг ашиглаж байна.

1.2.3.2 Уг программыг ашиглаж байгаа эцсийн хэрэглэгч болох төсвийн байгууллагын удирдлага, нягтлан бодогчдоос хэрэглэгчийн судалгаа авсан бөгөөд судалгааны үр дүн дараах байдалтай гарсан. (судалгаанд 91 хэрэглэгч хамрагдсан)

1.2.3.3 Төрийн сангийн цахим систем таны ажлын хэрэгцээг хэр хангаж байна вэ? асуултад нийт хэрэглэгчийн 65.9 хувь нь хэвийн, 34.1 хувь нь бүрэн хангасан гэж хариулжээ.

1.2.3.4 Судалгааны дүнгээс үзэхэд “Тус цахим системийн аюулгүй байдал хангагдсан гэж үзэж байна уу?” гэсэн асуултад оролцогчдын 49.4 хувь нь “тийм”, 45.0 хувь нь “мэдэхгүй”, 5.6 хувь нь “үгүй” гэж хариулсан байна.

График 1. Цахим системийн хүндрэл, бэрхшээлийн судалгаа



(Эх сурвалж: Хэрэглэгчийн судалгаа)

1.2.3.5 Мөн төрийн сангийн цахим системийн ашиглалт, хүртээмж, найдвартай байдал, бусад системтэй хэрхэн холбогддог, сайжруулах талаар санал байвал товч бичнэ үү гэсэн асуултад системд сайжруулалт хийх 24, сургалт зохион байгуулах 7 санал ирүүлсэн байна.

1.2.3.6 Судалгааны үр дүнгээс үзэхэд төрийн сангийн цахим систем нь хэрэглэгчдийн өдөр тутмын ажлын хэрэгцээг ерөнхийдөө хангаж байгаа боловч мэдээллийн аюулгүй байдлын талаарх хэрэглэгчдийн ойлголт, итгэл хангалттай түвшинд бүрдээгүй байна. Тухайлбал, оролцогчдын 49.4 хувь нь системийн аюулгүй байдал хангагдсан гэж үзсэн бол 45.0 хувь нь энэ талаар тодорхой мэдлэггүй гэж хариулсан нь хэрэглэгчдийн мэдээллийн аюулгүй байдлын ойлголт, мэдлэгийг сайжруулах шаардлагатайг харуулж байна.

1.2.3.7 Түүнчлэн системийг сайжруулах болон хэрэглэгчдэд чиглэсэн сургалт зохион байгуулах санал давамгайлж байгаа нь системийн ашиглалт, хүртээмж, найдвартай байдлыг цаашид сайжруулах хэрэгцээ байгааг илтгэж байна.

Бүлэг 2 Төрийн сангийн үйл ажиллагаа хууль тогтоомжийн хүрээнд хэрэгжсэн ч санхүүжилт олголт, анхан шатны баримтын бүрдэл, эдийн засгийн ангиллын хяналт, дотоод хяналтын хэрэгжилтийг сайжруулах шаардлагатай байна.

2.1 Төсвийн санхүүжилт, зарцуулалтын эрх олголт нь батлагдсан төсөв, хуваарьт тулгуурлан хэрэгжсэн боловч санхүүжилтийг хугацаанд нь бүрэн олгоогүй, зарцуулах эрхийг олгоогүйгээс шалтгаалан төсөл, арга хэмжээ хойшилж, өр төлбөр нэмэгдсэн байна.

2.1.1 Орон нутгийн төсвийн байгууллагуудын санхүүжилтийн эрхийг журамд заасан хугацаа, хуваарийн дагуу тогтмол олгоогүйгээс төлөвлөлт, гүйцэтгэлийн уялдаа алдагдах эрсдэлтэй байна.

2.1.1.1 Төсвийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1.8, Төрийн сангийн үйл ажиллагааны журмын 2.6-т заасан журмаар орон нутгийн төсвийн санхүүжилтийн эрх олгох чиг үүргийг зохицуулсан байна.

2.1.1.2 Орон нутгийн төсвийн байгууллага болон сумдад санхүүжилтийн эрхийг батлагдсан маягтын (СЭБ-1, СЭБ-2) дагуу баталгаажуулан олгож байна.

2.1.1.3 Санхүүжилтийн эрхийг холбогдох маягтын дагуу баталгаажуулан олгож байгаа ч зарим тохиолдолд батлагдсан төсвийн хуваарьтай бүрэн уялдуулаагүй байна. Мөн орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөөний хэрэгжилтээс шалтгаалан санхүүжилтийн эрхийг тухайн сард нэгээс олон удаа олгох тохиолдол гарч байна.

2.1.1.4 Санхүүжилтийн эрхийг Төрийн сангийн үйл ажиллагааны журмын 2.6.1-д заасан хугацаанд тогтмол, бүрэн олгоогүй байна. Санхүүжилтийн эрх олголтын давтамжийг түүвэрлэн үзэхэд 2023 оны 12 дугаар сард 10 удаа, 2024 оны 12 дугаар сард 7 удаа, 2025 оны 10 дугаар сард 15 удаа тус тус санхүүжилтийн эрх олгосон нь журамд заасан хугацааны шаардлагатай нийцэхгүй байна.

2.1.1.5 Энэ нь төсвийн байгууллагуудын 80101, 80111 зориулалтын зардлын санхүүжилтээс бусад хөтөлбөр, арга хэмжээний санхүүжилтийг батлагдсан хуваарийн дагуу олгохгүй, харин хэрэгцээ шаардлага үүссэн тухай бүрд хэсэгчлэн олгож байгаатай холбоотой байна. Үүний улмаас нэг сарын хугацаанд санхүүжилтийн эрхийг олон удаа олгох нөхцөл үүсэж, санхүүжилтийн эрх олголтын төлөвлөлт, хэрэгжилтийн тогтвортой байдал алдагдсан байна.

2.1.1.6 Санхүүжилтийн эрхийг журамд заасан хугацаанд олгохгүй байх нь төсвийн байгууллагуудын санхүүжилтийн төлөвлөлт, төсвийн гүйцэтгэлийн уялдааг сулруулж, зарим зардлыг хугацаанд нь санхүүжүүлэх боломжийг хязгаарлах, төлбөр тооцоо саатах, өр төлбөр үүсэх эрсдэлийг нэмэгдүүлэх сөрөг үр дагавартай байна. Улмаар байгууллагын хэвийн үйл ажиллагаа тасалдах нөхцөл бүрдэх эрсдэлтэй байна.

2.1.1.7 Харин сумдад олгох санхүүгийн дэмжлэгийг маягтын дагуу эрх бүхий албан тушаалтнаар баталгаажуулан батлагдсан төсвийн дагуу бүрэн олгосон байна.

Хүснэгт 3. 2023-2025 онд сумдад олгосон санхүүгийн дэмжлэгийн судалгаа

д/д	Сумын нэр	2023 он		2024 он		2025 он	
		Жилийн батлагдсан төсөв	Олгосон санхүүжилт	Жилийн батлагдсан төсөв	Олгосон санхүүжилт	Жилийн батлагдсан төсөв	Олгосон санхүүжилт
1	Асгат	678.6	678.6	971.8	971.8	896.5	896.5
2	Баяндэлгэр	606.8	606.8	757.0	757.0	696.9	696.9
3	Дарьганга	796.1	796.1	1,143.1	1,143.1	884.4	884.4
4	Мөнххаан	675.7	675.7	985.7	985.7	489.6	489.6
5	Наран	791.6	791.6	1,141.3	1,141.3	748.8	748.8
6	Онгон	652.0	652.0	850.1	850.1	196.2	196.2
7	Сүхбаатар	412.4	412.4	684.2	684.2	539.6	539.6
8	Түвшинширээ	845.4	845.4	1,129.8	1,129.8	918.6	918.6
9	Түмэнцогт	846.0	846.0	1,176.0	1,176.0	1,072.1	1,072.1
10	Уулбаян	700.9	700.9	1,063.6	1,063.6	1,080.8	1,080.8
11	Халзан	839.9	839.9	1,156.6	1,156.6	810.0	810.0
12	Эрдэнэцагаан	578.9	578.9	422.5	422.5	-	-
		8,424.3	8,424.3	11,481.7	11,481.7	8,333.5	8,333.5

(Эх сурвалж: Төсвийн ерөнхийлөн захирагчийн нэгтгэсэн тайлан)

2.1.1.8 Аймгийн төрийн сан орон нутгийн төсвийн байгууллагын санхүүжилтийн эрхийг 2025 оны жилийн эцсийн өссөн дүнгээр авч үзэхэд 8,418.2 сая төгрөг батлагдаж, 7,928.3 сая төгрөгийн санхүүжилт олгосон нь 489.9 сая төгрөгөөр буюу 5.8 хувиар дутуу санхүүжүүлсэн байна. Энэ нь 2025 оны сүүлийн хагаст эдийн засгийн тогтворгүй байдал үүсэж, төлөвлөсөн орлого тасрах, улмаар төсвийн

байгууллагуудын урсгал үйл ажиллагаа хэвийн хэрэгжих боломж хязгаарлагдах, зарим зардал хойшлогдох, өр төлбөр үүсэх эрсдэл нэмэгдэх, батлагдсан төсөв, төлөвлөгөөний хэрэгжилтэд сөргөөр нөлөөлөх үр дагавар үүссэн байна.

2.1.1.9 Орон нутгийн төсвийн орлого 2025 онд тасарснаас дамжуулан зээлдүүлсэн зээлийн эргэн төлөлтийг 1,041.0 сая төгрөгөөр төлөвлөсөн боловч санхүүжилтийг олгоогүйгээс уг хөтөлбөр, зориулалт хэрэгжээгүй байна.

2.1.2. Санхүүжүүлэх эрх олгоогүйгээс шалтгаалан төсөл арга хэмжээ хойшилж, өр төлбөр нэмэгдсэн байна

2.1.2.1 Аймаг, сумын төсөвт байгууллага, төрийн өмчийн барилгын тогтмол зардал, төсөл сангийн төсвийн зарцуулах эрхийг эдийн засгийн ангилал болон шаардлагад нийцүүлэн олгож байна.

2.1.2.2 Орон нутгийн төсвийн байгууллагын санхүүжилтийн эрх олгох жагсаалтаас (2025 оны 12 сарын өссөн дүн) харахад хөтөлбөр, зорилтын санхүүжилтийг батлагдсан төсвөөс хэтрүүлэн олгосон байна.

Хүснэгт 4. Зарцуулах эрх илүү олгосон судалгаа

Байгууллагын нэр	Хөтөлбөрийн код	Зориулалтын код	Батлагдсан төсөв	Зарцуулах эрх олгосон	зөрүү /6=4-5/
1	2	3	4	5	6
Аймгийн ИТХ	70105	80101	1,036.7	1,041.3	- 4.6
	70105	80111	36.5	37.1	- 0.6
Аймгийн ЗДТГ	70106	80802	68.6	69.2	- 0.6
ОНӨГ	70426	80111	24.5	25.3	- 0.8
	ДҮН		1,166.3	1,172.9	- 6.6

(Эх сурвалж. 2025 оны 12 сарын санхүүжилтийн эрх олгох жагсаалт)

2.1.2.3 Зарцуулах эрхийг батлагдсан төсвөөс илүү олгосон нь Төсвийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1.8⁵ дахь заалт, Төрийн сангийн үйл ажиллагааны журам”-д төсвийн батлагдсан хуваарь, зориулалт, эдийн засгийн ангилалд нийцүүлэн зарцуулалтын эрх олгохоор зохицуулалтыг зөрчсөн байна. Иймээс батлагдсан төсөв, хөтөлбөр, зориулалт, эдийн засгийн ангиллаас хэтрүүлэн зарцуулах эрх олгосон нь төсвийн сахилга бат алдагдах, төсвийн хөрөнгийг зориулалтын бусаар захиран зарцуулах эрсдэл үүсгэсэн тул зөрчлийн арилгах албан шаардлага хүргүүлээ.

2.1.2.4 Улсын хэмжээнд эдийн засгийн хүндрэл, төсвийн орлого тасарсан нөхцөл байдлаас шалтгаалан Сангийн яамнаас Засаг даргын нөөц сан, Байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардал, мөрийн хөтөлбөр хэрэгжүүлэх зардал, их засвар, орон нутгийн хөрөнгө оруулалтын зардлын санхүүжих эрхийг олгоогүйгээс төлөвлөсөн төсөл арга хэмжээ хэрэгжээгүй хойшилсон байна. Мөн орон нутгийн төсвийн байгууллагын цалин, НДШ-ийн зардлаас бусад зардлын санхүүжих эрхийг тавиагүйгээс богино хугацаат өр төлбөр нэмэгдсэн сөрөг үр дагавар гарсан байна. Тухайлбал орон нутгийн төсвийн орлогын үлдэгдлийг зарцуулах эрх олгоогүйгээс богино хугацаат өр төлбөр данс оны үзүүлэлтээс 14,278.7 сая төгрөгөөр нэмэгдэж Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8⁶-д заасан зарчим алдагдахад нөлөөлжээ.

⁵ төсвийн сар, улирлын хуваарьт үндэслэн төсвийн байгууллагын бүртгэлийн дансанд санхүүжилтийн болон зарцуулалтын эрх олгох

⁶ төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх.

2.1.2.5 Сангийн яамнаас 2025 оны сүүлийн хагаст зарцуулах эрхийг олгоогүйгээс аймгийн орон нутгийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэхээр төлөвлөсөн 64 төсөл, арга хэмжээний санхүүжилт саатаж, хэрэгжилт хойшилсон байна. Үүний зэрэгцээ төсвийн байгууллагуудын богино хугацаат өр төлбөр нэмэгдэж, төлбөр тооцоог хугацаанд нь гүйцэтгэх боломж хязгаарлагдсан нь төсвийн төлөвлөлт, гүйцэтгэлийн уялдаа алдагдах эрсдэлийг нэмэгдүүлсэн байна.

2.1.2.6 Төсвийн бодлого хариуцсан ахлах мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтын 1.1-т төсвийн хөрөнгийн үр ашигтай зарцуулалтад хяналт тавьж дүгнэлт гаргах, чиг үүргийг тусгасан байна. Тус мэргэжилтэн орон нутгийн төсвийн хөрөнгийн зарцуулалттай холбоотой судалгаа, шинжилгээ хийх, хяналт хэрэгжүүлэх, дүгнэлт гаргах чиг үүргийг үр дүнтэй хэрэгжүүлээгүй байна.

2.1.2.7 Улсын болон орон нутгийн төсвийн байгууллага нэмэлт төсвийн зарцуулалтын эрхийн хүсэлтийг харьяалах төрийн санд ирүүлснийг үндэслэн эдийн засгийн ангиллаар зарцуулах эрхийг олгож байна.

2.1.2.8 Гэвч төрийн байгууллагууд чиг үүрэг, хөтөлбөр арга хэмжээнд үндэслэн эдийн засгийн ангиллын дагуу хүсэлт өгч зарцуулах эрх авдаггүйгээс дараах үр дагавар гарч байна. Тухайлбал:

- Эрүүл мэндийн газар, Боловсролын газар, аймаг, сумын ЗДТГ зэрэг улсын болон орон нутгийн төсвийн байгууллагууд төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус сургалтын үйл ажиллагаатай холбоотой цайны болон үдийн хоолны зардлыг заавар, аргачлалын дагуу “Сургалт, дадлага, бэлтгэлийн зардал” буюу эдийн засгийн ангиллын 210902-т төлөвлөж, зарцуулах ёстой байхад “Хоол, хүнс” буюу 210502 ангиллаар төлбөр тооцоог гүйцэтгэж байгаа нь Сангийн сайдын 2025 оны 112 дугаар тушаалын хоёрдугаар хавсралтаар баталсан ангилалтай нийцэхгүй байна.

2.1.2.9 Иймд аймаг, сумын төрийн сангийн эрх бүхий албан тушаалтнууд нэмэлт санхүүжилтийн дансны зарцуулах хүсэлтийг хянаж, зарцуулах эрх олгохдоо төсвийн зориулалт, эдийн засгийн ангилал, холбогдох хууль эрх зүйн акттай нийцүүлэн шийдвэрлэж байх нь төсвийг зөв ангиллын дагуу захиран зарцуулах, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, санхүүгийн сахилга бат, хяналтыг сайжруулах зэрэг үр нөлөөтэй байна.

2.1.2.10 Улсын төсвийн байгууллагад дээд шатны байгууллагаас санхүүжилт олгох зардлын эдийн засгийн ангиллын дагуу зардал тус бүрд олгохгүй зөвхөн нэг төрлийн зардлын ангилалд олгож байгаа нь Сангийн сайдын 112 дугаар тушаалаар баталсан эдийн засгийн ангилалд нийцэхгүй төрийн сангийн гүйлгээг хянаж, баталгаажуулахад хүндрэл, үл ойлголцол үүсэх зэрэг учир дутагдалтай байна.


2.2 Төрийн сангийн нэгдсэн данс, төлбөр тооцооны үйл ажиллагаа хууль, журмын дагуу хэрэгжиж байгаа боловч зарим гүйлгээнд анхан шатны баримтын бүрдэл дутуу, эдийн засгийн ангиллын дагуу хянаж баталгаажуулаагүй зөрчил илэрч байна.

2.2.1 Орон нутгийн төрийн сангийн дансны үлдэгдлийг Сангийн яам болон Монгол банкны үлдэгдэлтэй тулган баталгаажуулж, санхүүгийн тайланд тусган аудитаар баталгаажуулсан нь холбогдох журмын дагуу хэрэгжсэн байна.

2.2.1.1 Орон нутгийн төрийн сан Засгийн газрын 2023 оны 444 дүгээр тогтоолоор батлагдсан "Төрийн сангийн үйл ажиллагааны журам"-ын 3.4.24⁷-т заасны дагуу төрийн сангийн дансны үлдэгдлийг Сангийн яамтай тооцоо нийлж баталгаажуулсан.

2.2.1.2 Аймгийн хэмжээнд төрийн сангийн дансны үлдэгдлийг Сангийн яам болон Монгол банкны үлдэгдэлтэй тулган баталгаажуулж, орон нутгийн төрийн санд хүргүүлсэн байна. Төсвийн ерөнхийлөн захирагчийн дансны үлдэгдлээс үзэхэд жил бүр 23,271.6-30,827.6 сая төгрөгийн үлдэгдлийг санхүүгийн тайланд тусгаж, тухайн оны санхүүгийн тайлангийн аудитаар баталгаажуулжээ. Төсвийн ерөнхийлөн захирагчийн дансны үлдэгдлийг данс тус бүрээр харуулбал.

График 2. Дансны үлдэгдлийн судалгаа



(Эх сурвалж: Данс үлдэгдлийн баталгаа)

2.2.1.3 Судалгааны дүнгээс үзэхэд дансны үлдэгдлийн дийлэнх хувийг орон нутгийн ерөнхий орлогын дансны үлдэгдэл бүрдүүлж, нийт үлдэгдлийн 28–44 хувийг эзэлж байна. Энэ нь төсвийн байгууллагын болон хуульд зааснаас бусад төрийн сангийн дансны зарцуулагдаагүй үлдэгдлийг орон нутгийн ерөнхий орлогын дансанд төвлөрүүлдэг зохицуулалттай холбоотой байна.

2.2.1.4 Харин 2025 оны байдлаар нийт дансны үлдэгдлийн 45 хувь, буюу 13,002.9 сая төгрөгийг ОНХС-ийн дансны үлдэгдэл эзэлж байгаа бөгөөд тайлант онд төлөвлөсөн хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалт, төсөл, арга хэмжээг бүрэн хэрэгжүүлээгүйтэй холбоотой байна. Энэ нь эдийн засгийн хүндрэлтэй нөхцөл байдлын улмаас төсвийн зарцуулах эрхийг бүрэн олгоогүй нь нөлөөлсөн байна.

⁷ Энэ журмын 3.4.1, 3.4.2-т заасан албан тушаалтан бүртгэлийн дансны үлдэгдлийн баталгааг мөн журмын 5 дугаар хавсралтад заасан маягын дагуу үйлдэн хагас жил тутам харьяа төрийн сантай тооцоо нийлж баталгаажуулна.

2.2.1.5 Сангийн яамнаас зарцуулах эрхийг нэгдсэн байдлаар зохицуулж байгаа өнөөгийн тогтолцоо нь орон нутгийн төсвийн хэрэгжилтэд тодорхой хэмжээнд хязгаарлалт үүсгэж байна. Ялангуяа орон нутгийн ерөнхий орлогын дансны үлдэгдэл, тухайн шатны санхүүгийн бодит боломж, хэрэгцээнд тулгуурлан шуурхай шийдвэр гаргах нөхцөл хязгаарлагдсанаар төсвийн зарцуулалтын уян хатан байдал сулрах, төлөвлөсөн төсөл, арга хэмжээний хэрэгжилт саатах эрсдэл бий болж байна. Иймээс зарцуулах эрх олгох төвлөрсөн зохицуулалт нь орон нутгийн бие даасан байдлын зарчимтай хэр нийцэж байгааг нягтлан үзэж, шаардлагатай тохиолдолд холбогдох хууль, эрх зүйн зохицуулалтад өөрчлөлт оруулах асуудлыг судлах нь зүйтэй байна.

Орон нутгийн ерөнхий орлогын дансны үлдэгдлийг төрийн сан тус бүрээр харуулбал.

Хүснэгт 5. Ерөнхий орлогын дансны үлдэгдлийн судалгаа

д/д	Төрийн сангийн нэр	Ерөнхий орлогын дансны дугаар	Мөнгөн дүн (сая төгрөгөөр)		
			2023 он	2024 он	2025 он
1	Аймгийн төрийн сан	100120000910	5,523.7	2,970.0	309.5
2	Асгат. Төрийн сан	100120100910	215.4	234.9	1,623.3
3	Баруун-Урт.Төрийн сан	100121300910	2,616.4	4,111.1	1,259.7
4	Баяндэлгэр. Төрийн сан	100120200910	34.6	348.1	248.5
5	Дарьганга. Төрийн сан	100120300910	105.1	181.8	1.6
6	Мөнххаан. Төрийн сан	100120400910	70.7	379.7	270.0
7	Наран. Төрийн сан	100120500910	271.1	459.2	268.0
8	Онгон.Төрийн сан	100120600910	481.8	822.2	232.9
9	Сүхбаатар.Төрийн сан	100120700910	94.6	57.4	1,210.9
10	Түвшинширээ.Төрийн сан	100120800910	119.5	345.6	196.6
11	Түмэнцогт. Төрийн сан	100120900910	214.4	277.3	401.6
12	Уулбаян. Төрийн сан	100121000910	102.6	128.0	425.9
13	Халзан. Төрийн сан	100121100910	281.8	507.1	188.1
14	Эрдэнэцагаан. Төрийн сан	100121200910	580.7	1,067.5	1,577.3
Нийт дүн			10,712.4	11,889.9	8,213.9

(Эх сурвалж: Данс үлдэгдлийн баталгаа)

2.2.1.6 Хүснэгтийн мэдээллээс харахад төрийн сангийн ерөнхий орлогын дансны үлдэгдэл 2023 онд 10,712.4 сая төгрөг, 2024 онд 11,889.9 сая төгрөг болж өссөн боловч 2025 онд 8,213.9 сая төгрөг болж буурсан байна. Гэсэн хэдий ч 2025 оны үлдэгдлийн бүтцээс үзэхэд Эрдэнэцагаан, Асгат, Баруун-Урт, Сүхбаатар сумдын төрийн сангийн дансны үлдэгдэл харьцангуй өндөр байна. Энэ нь төсөв, санхүүжилтийн зарцуулалт, төвлөрүүлэлтийн явц жигд бус, зарим шатанд мөнгөн хөрөнгийн удирдлага, ашиглалтын үр ашиг харилцан адилгүй байгааг илтгэж байна. Иймд дансны үлдэгдлийн өсөлт, бууралтын шалтгааныг нарийвчлан судалж, үлдэгдэл өндөр төвлөрсөн төрийн сангуудад мөнгөн хөрөнгийн төлөвлөлт, зарцуулалт, хяналтыг сайжруулах шаардлагатай байна.

2.2.2 Төрийн сангийн төлбөр, тооцооны гүйлгээг анхан шатны баримтын бүрдэл хангалтгүй, эдийн засгийн ангиллын дагуу хянаж баталгаажуулахгүйгээр гүйцэтгэсэн нь дотоод хяналт, төсвийн сахилга бат, хариуцлагын тогтолцоог сулруулах эрсдэлтэй байна.

2.2.2.1 Аймгийн хэмжээнд төрийн сангийн үйл ажиллагаа 14 нэгжээр дамжин хэрэгжиж, улсын болон орон нутгийн төсөвт байгууллагуудын санхүүжилт, төлбөр тооцоо, бүртгэлийн үйл ажиллагааг нийт 985 дансаар дамжуулан гүйцэтгэж байна.

2.2.2.2 Төрийн сангийн дансаар 2023–2025 онд төсвийн байгууллагын урсгал үйл ажиллагаа, тусгай сан, хөрөнгө оруулалт, төсөл, арга хэмжээний орлого, зарлагын нийт 245,156 гүйлгээ хийгдсэнээс 36 хувь буюу 87,850 гүйлгээг аймгийн төрийн сангаар дамжуулан гүйцэтгэсэн байна. Төрийн сангийн гүйлгээний тоог аймаг, сум тус бүрээр харуулбал дараах байдалтай байна.

Хүснэгт 6. Төрийн сангийн гүйлгээний судалгаа

д/д	Төрийн сангийн нэр	Гүйлгээ		Гүйлгээний тоо		
		хийх албан тушаалтны тоо	хянаж, батлах албан тушаалтны тоо	2023 он	2024 он	2025 он
1	Аймгийн төрийн сан	2	1	27,884	33,436	26,255
2	Асгат. Төрийн сан	1	1	3,319	3,561	3,628
3	Баруун-Урт.Төрийн сан	1	1	11,286	10,590	10,946
4	Баяндэлгэр. Төрийн сан	1	1	3,473	3,586	3,957
5	Дарьганга. Төрийн сан	1	1	3,625	3,906	3,562
6	Мөнххаан. Төрийн сан	1	1	3,463	3,983	4,039
7	Наран. Төрийн сан	1	1	2,578	2,913	2,905
8	Онгон.Төрийн сан	1	1	3,266	3,680	4,284
9	Сүхбаатар.Төрийн сан	1	1	3,000	3,396	3,534
10	Түвшинширээ.Төрийн сан	1	1	3,253	3,609	3,105
11	Түмэнцогт. Төрийн сан	1	1	2,887	2,913	3,079
12	Уулбаян. Төрийн сан	1	1	3,243	3,646	3,853
13	Халзан. Төрийн сан	1	1	3,149	2,992	2,924
14	Эрдэнэцагаан. Төрийн сан	1	1	4,226	3,917	4,030
Нийт дүн		15	14	78,652	86,128	80,101

(Эх сурвалж: Төрийн сангийн гүйлгээний ерөнхий журнал)

2.2.2.3 Аймгийн төрийн сан бүх жилд хамгийн өндөр ачаалалтай ажилласан бөгөөд 2024 онд 33,436 гүйлгээ, 2025 онд 26,255 гүйлгээ хийгдсэн нь бусад сумдаас их үзүүлэлттэй байна. Мөн Баруун-Урт сумын төрийн сан тогтмол ачаалалтай байгаа бөгөөд 2025 онд 10,946 гүйлгээ хийсэн нь сумдын дунджаас хамгийн өндөр үзүүлэлт юм.

2.2.2.4 Харин бусад сумдын төрийн сангуудын гүйлгээний хэмжээ харьцангуй ойролцоо боловч Онгон, Мөнххаан, Эрдэнэцагаан сумдын гүйлгээний тоо 2025 онд өссөн байна. Энэ нь тухайн сумдын төсөв, санхүүгийн үйл ажиллагааны идэвх нэмэгдсэнийг илтгэж байна. Нөгөө талаар Халзан, Түвшинширээ сумдын гүйлгээний тоо буурсан нь ачаалал харьцангуй багассаныг харуулж байна.

2.2.2.5 Төрийн санд ашиглагдаж байгаа тэмдэг, баталгааны тэмдгийн бүртгэлийг үйл ажиллагааны журмын 3.10.5⁸-т заасны дагуу бүртгэж жил бүр төв төрийн санд хүргүүлэх ажлыг хугацаанд нь хэрэгжүүлж хэвшсэн байна.

2.2.2.6 Төрийн сангийн орлого, зарлагын гүйлгээг Төсвийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1.5⁹-д заасны дагуу цахим хэлбэрээр гүйцэтгэж, төлбөр тооцооны баримтыг төсвийн захирагч цахим гарын үсгээр баталгаажуулж байна. Энэ нь

⁸ Аймаг, нийслэлийн төрийн сан, төрийн захиргааны төв байгууллагын төрийн сангийн нэгж төрийн сангийн тэмдэг, баталгааны тэмдгийн бүртгэлийг хөтөлж, дараа жилийн 01 дүгээр сарын 15-ны өдрийн дотор төв төрийн санд цахимаар, эсхүл албан бичгээр хүргүүлнэ

⁹ төсвийн гүйлгээг цахим системээр хэрэгжүүлж хяналт тавих;

Цахим гарын үсгийн тухай хууль болон Төрийн сангийн үйл ажиллагааны журмын шаардлагатай нийцэж, гарын үсгээр баталгаажуулах ажил гүйлгээ гарах эрсдэлийг бууруулсан эерэг үр дүнтэй байна.

2.2.2.7 Төрийн сангийн ажил гүйлгээнээс түүвэрлэн сонгосон зардлын баримтыг эдийн засгийн ангиллын дагуу зарцуулсан эсэхийг тулган баталгаажуулж, нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхэд зарим зардлыг Сангийн сайдын 2023 оны 211 дүгээр тушаалын, 2025 оны 112 дугаар тушаалын хоёрдугаар хавсралтаар баталсан зааварт нийцүүлэн захиран зарцуулаагүй байна.

Хүснэгт 7 Эдийн засгийн ангиллын дагуу зарцуулаагүй зардлын судалгаа (сая төгрөгөөр)

д/д	Дансны код	2023 он		2024 он		2025 он	
		тоо	мөнгөн дүн	тоо	мөнгөн дүн	тоо	мөнгөн дүн
1	210101-210105 - Цалин нэмэгдэл	9	5.3	6	4.7	1	0.3
2	210301- Гэрэл, цахилгаан	10	3.4	21	8.3	15	13.5
3	210302-Түлш, халаалт	12	8.9	6	7.7	13	4.0
4	210303-Цэвэр бохир ус	25	7.8	10	1.5	26	7.9
5	210501-Эм, эмнэлгийн хэрэгсэл			14	23.4	4	2.9
6	210502-Хоол, хүнс	18	21.0	19	16.3	33	58.7
7	210801-Мэргэжлийн үйлчилгээний төлбөр	28	10.5	6	2.9	16	1.7
8	210901-Бараа үйлчилгээний бусад зардал	11	2.3	6	21.9	19	9.7
	ДҮН	113	59.2	88	86.7	127	98.7

(Эх сурвалж: Төрийн сангийн гүйлгээний ерөнхий журнал)

2.2.2.8 Түүвэр судалгаанаас харахад 2023-2025 онд нийт 328 удаагийн 244.6 сая төгрөгийн төсвийн зарлагын гүйлгээ эдийн ангилалд хамаарахгүй зардал байхад төрийн сангийн мэргэжилтэн, санхүүгийн албаны дарга нар хянахгүйгээр гүйлгээг гаргаж байгаа нь албан тушаалын тодорхойлолтод заасан чиг үүргийг хэрэгжүүлээгүй, Төсвийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1.2¹⁰, 37.1.4¹¹, 37.1.5¹² дахь заалт, Төрийн сангийн үйл ажиллагааны журмын 3.4.10¹³-т заасныг зөрчсөнд албан шаардлага хүргүүлээ.

2.2.2.9 Төрийн сангийн удирдлагын цахим систем /finance.gov.mn/-ээр хийгдсэн зарлагын гүйлгээг түүвэрчлэн анхан шатны баримттай тулган баталгаажуулахад, харилцагч байгууллагаас ирүүлсэн нэхэмжлэхэд худалдан авсан бараа, материал, тоног төхөөрөмжийн нэр төрөл, тоо хэмжээ, нэгж үнэ зэрэг мэдээллийг тодорхой тусгалгүй, “хүнс”, “эм”, “бараа материал” зэрэг ерөнхий нэршлээр бөөн дүнгээр бичсэн, шаардлага хангаагүй нотлох баримтыг үндэслэн гүйлгээ хийсэн байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13¹⁴, 14¹⁵ дүгээр зүйл, Төрийн сангийн үйл ажиллагааны журмын 3.4.10-т заасантай нийцээгүй байна.

2.2.2.10 Төрийн сангийн удирдлагын цахим системийн ажил гүйлгээнд хийсэн дүн шинжилгээгээр Баруун-Урт суманд зочид буудал, хоол үйлдвэрлэлийн чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг томоохон 3 аж ахуйн нэгжид улсын болон орон нутгийн төсвийн байгууллагуудаас 2023-2025 онд 1,026.1 сая төгрөг шилжүүлсэн нь төсвийн

¹⁰ төсвийн орлого, зарлагын өдөр тутмын гүйлгээг хийх;

¹¹ төсвийн зарлагын төлбөрийн дарааллыг тогтоох;

¹² төсвийн гүйлгээг цахим системээр хэрэгжүүлж хяналт тавих;

¹³ Төрийн сан төсвийн байгууллагын төлбөрийн хүсэлтийг төлбөр гүйцэтгэхэд үндэслэх санхүүгийн анхан шатны баримттай тулган, батлагдсан төсвийн зарцуулалтын эрх, хөтөлбөр, зориулалт, арга хэмжээ, эдийн засгийн ангилал, ирүүлсэн мэдээлэлд үндэслэн ажлын 3 өдрийн дотор төлбөрийг гүйцэтгэх ба шаардлага хангаагүй тохиолдолд гүйлгээг буцаана;

¹⁴ Нягтлан бодох бүртгэлийн анхан шатны баримт

¹⁵ Нягтлан бодох бүртгэл хөтлөх

хөрөнгийн зарцуулалт зориулалт, үр ашиг, арвилан хэмнэлтийн зарчимд нийцээгүй байх эрсдэлийг илэрхийлж байна.

Хүснэгт 8. Хоол үйлдвэрлэлийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгжид мөнгөн хөрөнгө шилжүүлсэн судалгаа

д/д	Байгууллагын нэр	Зарцуулсан мөнгөн дүн (сая. төг)		
		2023 он	2024 он	2025 он
1	Дарьганга катеринг ХХК	239.8	151.7	79.8
2	Баруун-Урт тансаг ХХК	100.9	174.7	110.5
3	Өөдлөн тэмүүлэх оргил ХХК	44.4	62.3	62.0
НИЙТ ДҮН		385.1	388.7	252.3

(Эх сурвалж: Төрийн сангийн гүйлгээний ерөнхий журнал)

2.2.2.11 Дээрх дурдсан нөхцөл байдлаас дүгнэхэд анхан шатны баримтын бүрдэл дутуу, зарлагын эдийн засгийн ангиллыг хянаж баталгаажуулахгүйгээр ажил гүйлгээ хийж байгаа нь төрийн сангийн албан хаагч албан тушаалын тодорхойлолтод заасан чиг үүргээ бүрэн хэрэгжүүлээгүй, мөн тухайн ажил гүйлгээг түргэн шуурхай гаргах талаар дээд шатны удирдлагаас нөлөөлөл, шахалт үзүүлэх эрсдэл байгааг харуулж байна.

2.2.2.12 Иймд төрийн сангийн албан хаагч нь Төрийн албаны тухай хуульд заасан хууль дээдлэх, төрийн ашиг сонирхлыг хувийн ашиг сонирхлоос дээгүүр тавих, шударга, хариуцлагатай, хараат бус ажиллах зарчмыг чанд мөрдөж, төлбөр тооцоог бүрэн гүйцэд анхан шатны баримт, холбогдох нотлох материалд үндэслэн, зориулалт болон эдийн засгийн ангилалд нийцүүлэн хянаж баталгаажуулсны үндсэн дээр гүйцэтгэх шаардлагатай байна. Энэ нь төсвийн хөрөнгийг буруу ангиллаар зарцуулах, хяналтгүйгээр гүйлгээ баталгаажуулах, улмаар төсвийн сахилга бат, дотоод хяналтын тогтолцоог сулруулах сөрөг үр дагавар үүсэх эрсдэлтэй байна.

2.2.3. Төрийн сангийн гүйлгээний буцаалт, амжилтгүй гүйлгээ нь төсвийн багцын хүрэлцээгүй байдал, мэдээлэл-баримтын бүрдүүлэлт болон бүртгэлийн хяналтаас голлон шалтгаалж байна

2.2.3.1 Төрийн сангийн бүртгэлийн дансны орлогын хуулгыг түүвэрлэн шалгахад тодорхойгүй орлого байршуулаагүй байна. Харин төрийн сангийн дансны гүйлгээг тулган үзэхэд гурван жилийн хугацаанд 23,513.7 сая төгрөгийн 9,172 орлого, зарлагын гүйлгээг буцаажээ. Буцаасан гүйлгээг орлого тус бүрээр харуулбал.

Хүснэгт 9. Буцсан гүйлгээний судалгаа (сая төгрөгөөр)

Үзүүлэлт	2023		2024		2025	
	тоо	дүн	тоо	дүн	тоо	дүн
Буцаасан орлого	50	184.8	23	802.0	23	38.9
Буцаасан зарлага	3,584	5,975.3	2,470	7,410.5	3,022	9,102.2
Нийт	3,634	6,160.1	2,493	8,212.5	3,045	9,141.1

(Эх сурвалж: Төрийн сангийн гүйлгээний ерөнхий журнал)

2.2.3.2 Зарлагын гүйлгээнд түүвэрчлэн дүн шинжилгээ хийхэд дараах зөрчил, алдаа илэрсэн тохиолдолд тухайн гүйлгээг буцааж байна. Үүнд:

- Хөтөлбөр, зориулалт, эдийн засгийн ангилал буруу тусгасан;

- Хяналтын хэсэгт анхан шатны баримт дутуу бүртгэсэн, баримтын иж бүрдэл хангагдаагүй;
- Төлбөрийн хүсэлтэд тусгасан мөнгөн дүн, үндэслэх анхан шатны баримтын дүнгээс хэтэрсэн;
- Төрийн сангийн ажилтан 72 цагийн дотор баталгаажуулаагүйгээс шалтгаалан гүйлгээг буцааж байна.

2.2.3.3 Харин дараах тохиолдолд зарлагын гүйлгээг алдаатай гэж үзэн амжилтгүй гүйлгээнд бүртгэж, цуцалж байна.

Хүснэгт 10. Амжилтгүй гүйлгээний судалгаа (сая төгрөгөөр)

д/д	Амжилтгүй гүйлгээний утга	2023 он		2024 он		2025 он	
		тоо	дүн	тоо	дүн	тоо	дүн
1	Алдаатай үнийн дүн	10	112.4	2	0.1	2	4.0
2	Бэлтгэн нийлүүлэгчийн дансны дугаар бүртгэлгүй байх	43	64.1	1	0.01	248	2,697.9
3	Төлбөрийн эх үүсвэрийн байгууллагын данс кодын блокын данстай тохирохгүй байх	1	0.8	-	-	-	-
4	Төсвийн багц хүрэлцэхгүй байх	1,202	3,646.3	1,506	3,548.0	1,496	5,177.5
5	Үнийн дүн зөрүүтэй байх	103	110.7	1	11.7	1	10.4
6	Программын алдаа	905	1,301.7	-	-	-	-
7	Төсвийн сар нээгдээгүй	-	-	-	-	6	2.3
8	Гүйлгээ үүсгэх боломжгүй	-	-	-	-	2	14.5
нийт дүн		2,264	5,236	1,510	3,559.9	1,755	7,906.6

(Эх сурвалж: Төрийн сангийн гүйлгээний ерөнхий журнал)

2.2.3.4 Хүснэгтийн мэдээллээс харахад амжилтгүй гүйлгээний тоо 2023 онд 2,264, 2024 онд 1,510 болж буурсан боловч 2025 онд 1,755 болж дахин өссөн байна. Харин мөнгөн дүнгийн хувьд 2023 онд 5,236.0 сая төгрөг, 2024 онд 3,559.9 сая төгрөг байсан бол 2025 онд 7,906.6 сая төгрөг болж эрс нэмэгдсэн нь амжилтгүй гүйлгээний мөнгөн дүнгийн эрсдэл өндөр байгааг харуулж байна.

2.2.3.5 Амжилтгүй гүйлгээний шалтгааныг авч үзвэл бүх тайлант хугацаанд “Төсвийн багц хүрэлцэхгүй байх” шалтгааны тоо болон дүнгээр хамгийн өндөр хувийг эзэлж байгаа бөгөөд төсвийн төлөвлөлт, багцын хуваарилалт, зарцуулалтын уялдаа хангалтгүй байгааг илтгэж байна. Мөн 2025 онд “Бэлтгэн нийлүүлэгчийн дансны дугаар бүртгэлгүй байх” шалтгаант амжилтгүй гүйлгээ огцом өссөн нь мэдээллийн бүрдүүлэлт, бүртгэлийн хяналт сул байгааг харуулж байна.

2.2.3.6 Иймд амжилтгүй гүйлгээний голлох шалтгаан нь төсвийн багцын хүрэлцээ, төлбөрийн мэдээллийн үнэн зөв бүрдүүлэлт, системийн бүртгэлийн хяналттай холбоотой байгаа тул төсвийн төлөвлөлт, эрх олголт, мэдээллийн бүрдүүлэлтэд тавих урьдчилсан болон шаталсан хяналтыг сайжруулах шаардлагатай байна.

2.2.3.7 2023 онд “Программын алдаа”-аас шалтгаалсан амжилтгүй гүйлгээ харьцангуй өндөр байсан бол 2024-2025 онд энэ төрлийн зөрчил буурсан байна. Энэ нь ТСУЦС-ийн хэрэглэгчийн мэдлэг, мэдээлэл нэмэгдэж, систем ашиглах дадлага сайжирсан, мөн программ хангамжийн тохируулга, тогтвортой ажиллагаа тодорхой хэмжээнд сайжирсантай холбоотой гэж үзэхээр байна.

2.2.3.8 Ашигт малтмалын тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.2¹⁶-т заасны дагуу Асгат, Эрдэнэцагаан сумын нутаг дэвсгэрт ашигт малтмал олборлох үйл ажиллагаа

¹⁶ Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь энэ хуулийн 43.1.1-д зааснаас илүү хэмжээгээр гадаадын иргэдийг авч ажиллуулсан ажлын байр тутамд хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 10 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх, 43.1.2-т зааснаас бага хэмжээгээр орон

эрхэлж буй аж ахуйн нэгжүүдээс төвлөрүүлсэн ажиллах хүчний харьцааны төлбөрийг ЗДТГ-ын нэмэлт санхүүжилтийн дансанд байршуулсан байна.

2.2.3.9 Уг төлбөрийн орлогыг хуульд заасан зориулалтын дагуу төвлөрүүлж, зарцуулахад зориулсан тусгай данс нээлгэхээр Төрийн сангаас Сангийн яаманд хүсэлт хүргүүлсэн боловч тусгай данс нээх боломжгүй талаар мэдэгдэж, тухайн орлогыг ЗДТГ-ын төсвийн зарлагын хөтөлбөр, арга хэмжээнд тусган зарцуулах чиглэл өгсөн байна.

2.2.3.10 Иймд ажиллах хүчний харьцааны төлбөрийн орлогыг ЗДТГ-ын нэмэлт санхүүжилтийн дансаар төвлөрүүлж, цаашид төсвийн зарлагын хөтөлбөр, арга хэмжээнд тусган зарцуулах нь уг орлогын хуульд заасан зориулалт алдагдах, бусад төсвийн эх үүсвэртэй холилдон бүртгэгдэх, зарцуулалтын зориулалт, үр дүнг тусгайлан хянах боломж сулрах, тайлагнал ба ил тод байдал хангагдахгүй байх эрсдэлтэй тул төрийн сангийн данс нээлгэж Ашигт малтмалын тухай хуулийн 43.3-т заасан зориулалтаар төсөл арга хэмжээний жагсаалтыг ИТХ-аар батлуулж захиран зарцуулах нь илүү үр, дүн үр өгөөжтэй байна.

2.2.4 Төсвийн гүйцэтгэлийн мэдээг хугацаанд нь хүлээн авч баталгаажуулж байгаа ч мэдээллийг бүрэн цахимжуулж, систем хоорондын уялдаа, өгөгдөл солилцоог сайжруулах хэрэгцээ үүссэн байна.

2.2.4.1 Төрийн сангийн үйл ажиллагааны журамд заасны дагуу байгууллагын төсвийн гүйцэтгэлийн мэдээг баталгаажуулан сар бүрийн 02-ны өдрийн дотор цаасан хэлбэрээр, өглөг, авлагын мэдээг цахимаар хүргүүлж байна.

2.2.4.2 Төрийн сангийн эрх бүхий албан тушаалтан төсвийн гүйцэтгэлийн мэдээг олгосон санхүүжилт, гарсан зардалтай тулган шалгаж, илэрсэн алдааг тухай бүр засварлан дээд шатны байгууллагад хүргүүлж хэвшжээ.

2.2.4.3 Төрийн сангийн төлбөр тооцоо цахим хэлбэрээр хийгдэж байгаа хэдий ч төсвийн гүйцэтгэлийн мэдээг төсвийн захирагчийн тоон гарын үсгээр баталгаажуулан цахимаар хүлээн авдаг бол тухайн ажлыг хариуцаж буй нягтлан бодогчийн цаг хугацааг хэмнэхээс гадна, бага хэмжээгээр ч гэсэн бичиг хэргийн зардлыг бууруулах боломжтой байна.

2.2.4.4 Орон нутагт үйл ажиллагаа явуулж буй улсын төсвийн байгууллагууд төсвийн гүйцэтгэлийн мэдээг дээд шатны байгууллагад санхүүгийн программ ашиглан цахим хэлбэрээр хүргүүлж байна.

2.2.4.5 Иймд төрийн сангийн программ болон тухайн байгууллагын санхүүгийн программыг уялдуулан сайжруулж, сар бүрийн төсвийн гүйцэтгэлийн мэдээг цахим хэлбэрээр хүлээн авах нөхцөлийг бүрдүүлэх нь зүйтэй байна.

2.3 Дотоод болон хөндлөнгийн хяналтын тогтолцоо хэрэгжиж байгаа хэдий ч эрсдэлийн үнэлгээ, өдөр тутмын хяналт, хяналтын мөрөөр авах арга хэмжээний үр нөлөө хангалтгүй байвал зөрчил давтагдах, төлбөр тооцооны сахилга бат сулрах, төрийн сангийн үйл ажиллагааны найдвартай байдалд сөргөөр нөлөөлөх эрсдэлтэй байна.

нутгийн иргэдийг авч ажиллуулсан ажлын байр тутамд хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг хоёр дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төлбөрийг сар бүр төлнө.

2.3.1 Төв төрийн сангаас аймгийн төрийн санд дотоод хяналт хэрэгжүүлээгүй, дотоод хяналтаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтэд тавих хяналт, хариуцлагын механизм сул байгаагаас алдаа, зөрчил давтан гарч байна.

2.3.1.1 Төсвийн тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.6¹⁷ дахь хэсэгт төрийн үйл ажиллагаанд дотоод хяналт хэрэгжүүлэх тогтоолцоог ерөнхийд нь зохицуулсан бол Төрийн сангийн үйл ажиллагааны журмын 3.9¹⁸ дэх хэсэгт дотоод хяналтыг хэрэгжүүлэх хэлбэр, үйл явц, зохион байгуулалтыг нарийвчлан тодорхойлсон байна. Харин Сангийн сайдын 2024 оны 254 дүгээр тушаалын хавсралтаар “төрийн сангийн үйл ажиллагааны дотоод хяналтын заавар”-ыг шинэчлэн баталсан байна.

2.3.1.2 Тус хуулийн 36 дугаар зүйлийн 36.6 дахь хэсэгт зааснаар төв төрийн сан нь аймгийн төрийн сангийн үйл ажиллагаанд санхүүгийн дотоод хяналт хэрэгжүүлэх үүрэгтэй боловч 2022 оноос хойш уг хяналтыг хэрэгжүүлээгүй байна. Төв төрийн сангаас хяналт, хэрэгжүүлээгүй нь төв төрийн сангаас жилд дунджаар 2-3 аймгийн төрийн санд дотоод хяналт хэрэгжүүлэхээр төлөвлөдөг, дотоод хяналтын төлөвлөгөөг эрсдэлийн үнэлгээнд тулгуурлан боловсруулдаг зэрэгтэй холбоотой байна.

2.3.1.3 Харин аймгийн төрийн сан, сумдын санхүүгийн албаны үйл ажиллагаанд дотоод хяналт хэрэгжүүлэх төлөвлөгөөг 2024 онд А/129, 2025 онд А/63 дугаар захирамжаар тус тус баталсан байна. Дээрх захирамжийн хавсралтаар 2024 онд 6 суманд цахимаар, 7 суманд биечлэн, 2025 онд 13 суманд биечлэн очиж дотоод хяналт хэрэгжүүлэхээр төлөвлөжээ.

2.3.1.4 Төрийн сангаас 2024 онд хэрэгжүүлсэн дотоод хяналтын тайлангаас харахад биечлэн 2, цахим 6 суманд хэрэгжүүлсэн байна. Энэ нь Засаг даргын А/129 дүгээр захирамжаар баталсан төлөвлөгөө 61.5 хувьтай хангагдсан бол 2025 оны төлөвлөгөөний хэрэгжилтийг 100 хувь хангаж, тайлан, мэдээг дээд шатны байгууллагад хүргүүлсэн байна.

2.3.1.5 Дотоод хяналтаар илэрсэн алдаа зөрчилтэй холбогдуулан, төрийн сангийн болон орон нутгийн төсвийн байгууллагын санхүүгийн үйл ажиллагааг сайжруулахаар 2024 онд 14, 2025 онд 18 зөвлөмжийг тус тус хүргүүлсэн байна.

2.3.1.6 Дотоод хяналтын тайланг эрсдэл их гарсан 7 сумын төрийн санд албан бичгээр хүргүүлсэн боловч сумын төрийн сангаас зөвлөмжийг хэрэгжилтийг ирүүлээгүй байна. Төрийн сангийн үйл ажиллагааны дотоод хяналтын зааврын 8.1¹⁹-т зөвлөмжийн хэрэгжилтийн тайланг боловсруулж эрх бүхий албан тушаалтанд танилцуулж, төв төрийн санд хүргүүлэхээр тусгасан ч уг тайланг хүргүүлээгүй байна.

2.3.1.7 Төрийн сангийн үйл ажиллагаанд хэрэгжүүлсэн дотоод хяналтын нэгдсэн тайлангийн дүн, нөхцөл байдалд дүн шинжилгээ хийхэд өмнөх оны алдаа, зөрчлийг давтан гаргасан нь харагдаж байна. Тухайлбал:

¹⁷ Төв төрийн сан нь аймаг, нийслэл, улсын зэрэглэлтэй хотын төрийн сан болон төрийн захиргааны төв байгууллагын төрийн сангийн нэгжийн үйл ажиллагаанд, аймаг, нийслэл, улсын зэрэглэлтэй хотын төрийн сан нь сум, дүүрэг, орон нутгийн зэрэглэлтэй хот, тосгоны төрийн сангийн үйл ажиллагаанд санхүүгийн дотоод хяналтыг тус тус хэрэгжүүлнэ.

¹⁸ Төрийн сангийн үйл ажиллагааны дотоод хяналт:

¹⁹ Аймаг, нийслэлийн төрийн сан нь дотоод хяналтын нэгтгэсэн тайлан, зөвлөмжийн хэрэгжилтийг тухайн шатны засаг даргад танилцуулж, энэ зааврын хавсралт 8-д заасан дотоод хяналтын тайлангийн загварын дагуу нэгтгэн, энэ зааврын хавсралт 9-д заасан зөвлөмжийн хэрэгжилтийн тайлан, эрсдэлийн үнэлгээний нэгтгэлийн хамт төв төрийн санд дараа оны 1 дүгээр сарын 31-ний өдрийн дотор цахимаар болон албан бичгээр хүргүүлнэ.

- Гарын үсгийн баталгааны маягтыг шинэчилж, баталгаажуулаагүй;
- Цахим мэдэгдэл дээр данс, хэрэглэгчийн мэдээллийг буруу зөрүүтэй оруулах;
- Төрийн сангийн гүйлгээг журамд заасан хугацаанд баталгаажуулаагүй;
- Архивын нэгжийг тухай бүр үүсгэж хэвшээгүй зэрэг нийтлэг алдаа, зөрчлийг гаргасан байна;

2.3.1.8 Дотоод хяналтын баг тухайн төрийн санд илэрсэн алдаа, зөрчлийг хяналт шалгалтын явцад залруулах, арилгах арга хэмжээг авсан боловч зөрчил давтагдаж байгаа нь дотоод хяналтын мөрөөр авах арга хэмжээний хэрэгжилт тогтвортой хангагдаагүй, албан тушаалтны хариуцлага сул байгаатай холбоотой.

2.3.1.9 Төрийн сангийн үйл ажиллагааны журмын 3.9.10²⁰-т зөвлөмж хэрэгжүүлээгүй, алдаа зөрчил давтан гаргасан албан тушаалтанд хариуцлага тооцуулах санал хүргүүлэхээр тусгасан боловч уг арга хэмжээг хэрэгжүүлээгүй байна.

2.3.1.10 Дээрх нөхцөл байдлаас үзэхэд төрийн сангийн дотоод хяналтын үр нөлөө сулрах, хариуцлагын тогтолцоо алдагдах, хууль тогтоомжийн хэрэгжилт хангалтгүй байх эрсдэлтэй байна. Иймд дотоод хяналтын зөвлөмжийн хэрэгжилтийг хугацаанд нь нэгтгэн, удирдлага болон төв төрийн санд хүргүүлж, хэрэгжилтэд тогтмол хяналт тавьж ажиллах шаардлагатай байна.

2.3.2. Төрийн сангийн өдөр тутмын дотоод хяналтыг үр дүнтэй хэрэгжүүлээгүйгээс төлбөр тооцооны архивын нэгжийг үүсгэх ажил хангалтгүй байна.

2.3.2.1 Төлбөр тооцооны өдөр тутмын гүйлгээнд дотоод хяналт тогтмол хэрэгжиж, үр дүнг баталгаажуулан удирдлагад танилцуулах үйл ажиллагаа хэвшсэн байна.

2.3.2.2 Сумын санхүүгийн албаны дарга тухайн төрийн сангийн төлбөр, тооцооны гүйлгээнд өдөр тутмын хяналтыг хэрэгжүүлж байгаа хэдий ч цахим архивын нэгж үүсгэж, байгууллагын архивд хүлээлгэн өгөх чиг үүргийг хэрэгжүүлээгүй байна. Тухайлбал: 2023-2025 онд гарсан зарлагын гүйлгээг төрийн сан тус бүрээр түүвэрчлэн тулган баталгаажуулахад 12,543.5 сая төгрөгийн ажил гүйлгээг архивлаагүй байна. Энэ нь Төрийн сангийн үйл ажиллагааны журмын 3 дугаар зүйлийн 3.11.1²¹, 3.11.3.1²², 3.11.4²³, 3.11.5²⁴-т заасантай нийцээгүй байна.

2.3.2.3 Төрийн сангийн төлбөр тооцооны баримтыг тухай бүр архив үүсгэн хадгалж хэвшээгүй байгаа нь ашиглагдаж буй цахим системийн хэвийн үйл ажиллагаа доголдох, өгөгдөл алдагдах, системийн саатал үүсэх тохиолдолд гүйлгээг нотлох анхан шатны баримт устгах, гэмтэх, нөхөн сэргээх боломж хязгаарлагдах, улмаар төлбөр тооцооны үндэслэл, үнэн зөв байдал, хяналт шалгалтын мөрдөн

²⁰ Дотоод хяналтаар илэрсэн зөрчил, эрсдэлийг бууруулах талаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүйн улмаас дараагийн шалгалтаар дахин давтагдсан тохиолдолд тухайн албан тушаалтныг томилсон эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ.

²¹ Төрийн сан нь өдөр тутмын төлбөрийн баримтыг тухайн өдрийн зарлагын гүйлгээний жагсаалттай тулгаж, Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуулийн дагуу цахимаар хийгдсэн гүйлгээг цахим хэлбэрээр, цаасан хэлбэрээр хадгалагдах гүйлгээний баримтыг цаасан суурьтай хэлбэрээр архивын нэгж үүсгэж хадгална;

²² тухайн өдрийн зарлагын гүйлгээний жагсаалт;

²³ Төрийн сангийн мэргэжилтэн тухайн жилийн хүчингүй болсон гарын үсгийн баталгааг холбогдох баримтын хамт цахим болон цаасан хэлбэрээр архивын нэгж үүсгэнэ;

²⁴ Энэ журмын 3.11.1, 3.11.4-т заасан архивын нэгжийг төрийн сангийн мэргэжилтэн, архив хариуцсан мэргэжилтэн нар байгууллагын архивд хүлээлгэн өгнө.

баталгаажуулалт, хариуцлага тооцох нөхцөлийг сулруулах сөрөг үр дагавартай байна.

2.3.2.4 Иймд хариуцсан албан тушаалтан төлбөр, тооцооны баримтаар архивын нэгжийг өдөр бүр тухай бүр нь үүсгэн, дотоод хяналтаар шалгуулж, байгууллагын архивд хүлээлгэн өгч хэвших шаардлагатай байна.

2.3.2.5 Сангийн сайдын баталсан Төрийн сангийн үйл ажиллагааны дотоод хяналтын зааврын дагуу тухайн төрийн сангийн эрсдэлийн үнэлгээг 22 эрсдэлийн хүрээнд үнэлж байна.

2.3.2.6 Аймгийн төрийн сан 2024 онд үйл ажиллагааны эрсдэлийн нийт тоон түвшин 1-4 үнэлж, ач холбогдлын зэргийг бага, 2025 онд нэгдүгээр эрсдэл буюу хууль тогтоомжийн өөрчлөлтөөс үүдэн төсвийн хуваарилалт тасалдах эрсдэл 9 буюу дунд бусад эрсдэлийг бага гэж үнэлсэн байна.

2.3.2.7 Сумын төрийн сангийн 2024, 2025 оны эрсдэлийн үнэлгээний нэгтгэлээс харахад Асгат, Баруун-Урт, Баяндэлгэр, Онгон, Түмэн, Уулбаян, Эрдэнэцагаан сумын төрийн сан нийт эрсдэлийг ач холбогдлын зэргийг бага гэж үнэлжээ.

2.3.2.8 Асгат, Түмэнцогт сумын төрийн сан эрсдэлийн магадлал, нөлөөллийг огт гаргадаггүй буюу хамгийн багаар үнэлж байгаа нь нийцлийн хувьд тохиромжгүй харагдаж байна.

2.3.2.9 Төрийн сангийн дотоод хяналтын зааврын нэгдүгээр хавсралтаар баталсан эрсдэл гарах магадлал байгааг хариуцсан албан тушаалтан авч үзэх нь зүйтэй юм. Үүнд:

- Төрийн сангийн цахим болон цаасан архив хугацаандаа архивлахгүй байх;
- Сүлжээ болон тог тасрах;
- Орон нутгийн төсвийн орлогын бүрдүүлэлтээс хамаарч төсвийн санхүүжилтийг батлагдсан хуваариас зөрүүтэй олгох, төсвийн санхүүжилтийг журамд заасан хугацаанд олгохгүй байх эрсдэл тооцож үзэх нь зүйтэй байна.

2.3.2.10 Төрийн сангийн эрсдэлийн үнэлгээг бодит байдалд нийцүүлэхгүй байх нь дотоод хяналтын үр нөлөөг сулруулах, эрсдэлийг цаг тухайд нь илрүүлж бууруулах боломжийг хязгаарлах сөрөг үр дагавартай байна.

2.3.2.11 Харин Дарьганга сумын төрийн сан 9 эрсдэл дунд, 2 эрсдэл их, Мөнххаан сум 10 эрсдэл дунд, Сүхбаатар сум 9 эрсдэл дунд, Түвшинширээ сум 6 эрсдэл дунд, Наран, Халзан сумын төрийн сан 3 эрсдэлийн түвшинг тус бүр дунд гэж үнэлжээ.

2.3.2.12 Эрсдэлийн үнэлгээний нэгтгэлд дүн шинжилгээ хийхэд дараах эрсдэл их буюу дунд гэж үнэлэгдсэн байна. Тухайлбал:

- Төрийн сангийн албан хаагчдын тогтвор суурьшилтай ажиллах нөхцөлийг бүрдүүлэхгүй байх;
- Боловсон хүчний мэдлэг чадвар сул байх;
- Төсвийн санхүүжилтийг журамд заасан хугацаанд олгохгүй байх;
- Төсвийн байгууллага журамд заасан хугацаанд сарын мэдээг хүргүүлэхгүй байх;
- Хууль эрх зүйн актын хэрэгжилтийг хангаагүй, хяналтын хуудасны иж бүрдэл дутуу гүйлгээг хянан, баталгаажуулах;

- Зориулалт бус эх үүсвэрийн эдийн засгийн ангиллаас хийгдсэн гүйлгээг хянан баталгаажуулах;
- Төрийн сангийн цахим болон цаасан архив хугацаандаа архивлахгүй байх;
- Программ болон техник хангамжаас хамаарсан ажлын доголдол үүсэх;
- Сүлжээ болон тог тасрах;

2.3.2.13 Их буюу дунд үнэлсэн эрсдэлийг дотоод хяналтаар илэрсэн алдаа, зөрчилтэй харьцуулж үзэхэд эрсдэлийг үнэлж буй албан тушаалтан бодит байдалд нийцүүлэн үнэлсэн нь сайшаалтай байна.

2.3.2.14 Аймгийн төрийн сангийн дотоод хяналт хариуцсан албан тушаалтан эрсдэлийн үнэлгээг нэгтгэхдээ тухайн жилийн дотоод хяналтын тайлан, мэдээ, тайланд тулгуурлан засаж залруулах, бодит нөхцөл байдалд нийцүүлэх талаар мэргэжил, арга зүйн заавар, зөвлөгөө өгч ажиллах нь төрийн сангийн үйл ажиллагааны үр дүн, үр нөлөөг нэмэгдүүлэх боломжтой байна.

2.3.3 Өмнөх аудитын хэрэгжилтийг бүрэн хангагджээ

2.3.3.1 Төрийн сангийн тогтолцоо, үйл ажиллагааны үр дүн сэдэвт аудитыг 2018 онд нэгдсэн төлөвлөгөө, хөтөлбөрийн хүрээнд хийж гүйцэтгэжээ.

2.3.3.2 Тус аудитаар илэрсэн алдаа зөрчилтэй холбогдуулан 8 албан тушаалтанд хариуцлага тооцуулах албан шаардлага хүргүүлж, үйл ажиллагааны үр дүнг сайжруулах, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах 5 зөвлөмжийг шалгадагч байгууллагад хүргүүлсэн байна.

2.3.3.3 Албан үүргээ хангалтгүй хэрэгжүүлсэн албан тушаалтанд тухайн шатны Засаг даргын захирамж, ЗДТГ-ын даргын тушаалаар “Сануулах” сахилгын шийтгэл ногдуулсан бол зөвлөмжийн хэрэгжилтийг аймгийн ЗДТГ-ын СТСХ-ийн 2019 оны 06 дугаар сарын 20-ны өдрийн 6/833 албан бичгээр ирүүлсэн байна. Зөвлөмжийн хэрэгжилтийг авч үзвэл:

Хүснэгт 11. Зөвлөмжийн хэрэгжилтийн судалгаа

д/д	Зөвлөмжийн утга	Хэрэгжсэн нөхцөл байдал
1	Төсвийн ерөнхийлөн захирагчийн ерөнхий нягтлан бодогч буюу санхүү албаны дарга, нягтлан бодогчид тавигдах тусгай шаардлагыг үндэслэн томилгоог хийж хэвших, шаардлага хангахгүй байгаа албан тушаалтнуудыг мэргэжлийн байгууллагын сургалтад хамруулах	Нягтлан бодогчийг томилж чөлөөлөхдөө Сангийн сайдын баталсан “Төсвийн ерөнхий, ахлах нягтлан бодогчид тавигдах, шаардлага, шалгуур журам”-ыг баримтлан ажиллаж байна. Зарим тохиолдолд уг журмын заалтыг хангах боловсон хүчин дутмаг байгаа тул журамд өөрчлөлт оруулахыг дээд шатны байгууллагад уламжилсан.
2	Аймаг сумын үндсэн чиглэл, үйл ажиллагааны төлөвлөгөөнд төсвийн талаарх баримтлах бодлогын зорилтыг тодорхойлж, төсвийн хэрэгжилтийг үр ашигтай зохион байгуулах. Мөн сумдын санхүүгийн алба үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулж, хэрэгжилтийг тайлагнах, түүнд СТСХ-ээс арга зүйн зөвлөгөө өгч, хяналт тавих	Сумын ЗДТГ-ын санхүүгийн албаны ажлын төлөвлөгөөг гаргуулж албаны дарга, мэргэжилтэнд төсвийн төлөвлөлт, зарцуулалт, хөрөнгө оруулалтын үйл ажиллагаатай холбоотой сургалт зохион байгуулсан.
3	Төрийн сангийн төлбөр тооцоог гүйцэтгэхтэй холбогдуулан Төрийн сангийн үйл ажиллагааны журмыг зөрчсөн ажил гүйлгээг гаргахгүй байх, аудитаар илэрсэн зөрчлийг давтан гаргахгүй хэрэгжилтийг зохион байгуулах	Сумдын санхүүгийн албаны дарга, мэргэжилтэн нарт төлбөр тооцоотой холбоотой учирч болзошгүй эрсдэлийг бууруулах, цаашид анхаарч ажиллах тал дээр өдөр тутам зөвлөгөө өгч төлөвлөгөөний дагуу 2018, 2019 оны төрийн сангийн баримтад дотоод хяналтыг улирал бүр хэрэгжүүлэн зөвлөмжийн биелэлтийг ханган ажиллаж байна.

4	Системд нэвтрэх эрх бүхий хэрэглэгчийн нэр, нууц үгийг хадгалах, алдагдахаас сэргийлэх чиглэлээр урьдчилан сэргийлэх төлөвлөгөө боловсруулах, серверийн тоног төхөөрөмжийг лац, цоож цуургатай болгох, аюулгүй ажиллагааг хангаж ажиллах дүрэм журам боловсруулж, мөрдөх	Системд нэвтрэх хэрэглэгчийн нэр, нууц үгийг хадгалах, хамгаалах зорилготой Сангийн сайдын 90 дүгээр тушаалаар батлагдсан “ Засгийн газрын санхүүгийн удирдлагын мэдээллийн системд мөрдөх журам-ын хүрээнд томилолттой , чөлөөтэй, өвчтэй, чөлөөлөгдсөн зэрэг тохиолдолд уг журмын хавсралтын дагуу мэдээллийг сумдаас хүлээн авч эрсдэлгүй, аюулгүй ажиллагааг ханган ажиллаж байна.
5	Сумдын санхүүгийн алба ЗЭБ№1 маягтыг нэгдсэн нэг аргачлалаар бүрэн хөтөлж хэвших.	Зарим сумдын Сангийн сайдын 2012 оны 74 дүгээр тушаалаар батлагдсан Төсвийн санхүүжилтийн болон зарцуулалтын эрхийн тухай журам”-ын хавсралтаар батлагдсан маягтыг хөтлөлгүй санхүүжилт олгодог явдлыг бүрэн зогсоож зөвлөмжийн хэрэгжилтийг 100 хувь ханган ажиллаж байна.

(Эх сурвалж: Төрийн аудитын байгууллагын статистик мэдээ)

2.3.3.5 Өмнөх оны аудитаар өгсөн зөвлөмжийг бүрэн хэрэгжсэн гэж тайлагнасан байна.



Шалгагдагч байгууллагын саналтай холбоотой тайлбар.

Шалгагдагч байгууллагаас аудитын дүгнэлттэй холбоотой саналын зөрүүтэй асуудал ирүүлээгүй.



СҮХБААТАР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

Нутгийн удирдлагын ордон, 7 дугаар баг,
Баруун-Урт сум, Сүхбаатар аймаг, 22075
Утас: (976) 70518585
Цахим шуудан: info@sukhbaatar.gov.mn
Цахим хуудас: www.sukhbaatar.gov.mn

2026.05.27 № 06/655
танай _____-ны № _____-т

Санал хүргүүлэх тухай

“Төрийн сангийн тогтолцоо, үйл ажиллагааг тодорхойлсон бодлого, хууль тогтоомжийн нийцэл”-ийн аудитын тайлантай танилцаж дараах хариуг хүргүүлж байна.

Аудитаар илэрсэн зөрчлийг нэгтгэн харахад байгууллагын удирдлага, санхүү, бүртгэлийн ажилтнуудын ажлын туршлага, мэдлэг чадвар дутагдах, нөгөө талаар биднээс өгч буй сургалт мэдээллийг өдөр тутмын ажилдаа ашиглахгүй, мөрдлөг болгон хэрэгжүүлэхгүй байгаа зэрэг нь алдаа, зөрчил давтагдаж байна.

Иймд бид бүхэн танайхаас өгсөн зөвлөмж, чиглэлийн дагуу үйл ажиллагааг сайжруулан ажиллах болно.

САНХҮҮ, ТӨРИЙН САНГИЙН
ХЭЛТСИЙН ДАРГА



Д.АРИУНЖАРГАЛ

2226000110

ДҮГНЭЛТ:

Аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг гаргаж байна.

1. Төрийн сангийн үйл ажиллагааг зохицуулж буй эрх зүйн орчин нь Төсвийн тухай хуулийн үндсэн зохицуулалттай нийцэж байна. Цаашид “Төрийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 2.6.3 дахь заалтыг хүчин төгөлдөр зохицуулалттай нийцүүлэн засварлаж, зардлын санхүүжилтийн төрөл, баримт бичгийн бүрдэл, хянан баталгаажуулах дарааллыг тодорхой болгох шаардлагатай байна.
2. Төрийн сангийн чиг үүргийг хэрэгжүүлж буй албан хаагчдын албан тушаалын тодорхойлолтыг бодит ажил үүрэг, гарын үсгийн эрх, хууль, журам, ажлын ачаалал, дотоод хяналтын шаардлагатай уялдуулан шинэчлэх шаардлагатай байна. Ингэснээр чиг үүргийн давхардлыг бууруулж, хариуцлагын хүрээ, хяналт-тэнцлийн зарчмыг тодорхой болгох нөхцөл бүрдэнэ.
3. Төсвийн санхүүжилт, зарцуулалтын эрх олголт нь батлагдсан төсөв, хуваарьт тулгуурлан хэрэгжсэн боловч санхүүжилтийг хугацаанд нь бүрэн олгоогүй, зарцуулах эрхийг олгоогүйгээс шалтгаалан төсөл, арга хэмжээ хойшилж, өр төлбөр нэмэгдсэн байна.
4. Төрийн сангийн төлбөр тооцоонд анхан шатны баримтын бүрдэл, эдийн засгийн ангиллын хяналт, төлбөрийн мэдээллийн үнэн зөв байдлыг нэг мөр хангаагүйгээс төсвийн хөрөнгийн зориулалт, төлбөрийн үндэслэл, дотоод хяналтын үр нөлөөнд эрсдэл үүсэж байна. Иймд шаардлага хангасан анхан шатны баримт, эдийн засгийн зөв ангилал, баталгаажсан төсвийн зориулалтад үндэслэн гүйлгээг хянан баталгаажуулах шаардлагатай байна.
5. Төрийн сангийн тодорхойгүй орлогын эрсдэл харьцангуй бага байгаа ч буцсан болон амжилтгүй гүйлгээ нь төсвийн багцын хүрэлцээ, мэдээлэл-баримтын бүрдэл, бүртгэлийн хяналттай холбоотой байна. Иймд буцаалт, амжилтгүй гүйлгээний шалтгаан, залруулсан хугацаа, хариуцсан албан тушаалтан, давтан гарсан эсэхийг тусгайлан бүртгэж, урьдчилсан хяналтыг сайжруулах
6. Төрийн сан төсвийн гүйцэтгэлийн мэдээг хугацаанд нь хүлээн авч шалган баталгаажуулж байгаа нь хяналтын үйл явц хэрэгжиж байгааг харуулж байна. Цаашид төрийн сангийн систем, байгууллагын санхүүгийн программ, төсвийн гүйцэтгэлийн мэдээний цахим баталгаажуулалтыг уялдуулж, төсөв хоорондын тооцоо, тохируулгын тайланг хугацаа, зөрүү, залруулгын бүртгэлээр тусад нь хянах шаардлагатай байна.
7. Төсвийн санхүүжилт, зарцуулах эрх олголт батлагдсан төсөв, хуваарьт тулгуурлан хэрэгжиж байгаа бөгөөд орлогын бүрдэлт, мөнгөн хөрөнгийн хүрэлцээ, эрх олголтын хугацаатай холбоотой саатлыг бууруулах шаардлагатай байна. Санхүүжилтийн эрх олголтыг төсвийн хуваарь, орлогын гүйцэтгэл, мөнгөн хөрөнгийн төлөвлөлттэй уялдуулан тогтмол, бүрэн олгох нь зүйтэй.

ЗӨВЛӨМЖ:

Аудитын дүн, дүгнэлт нотлох зүйлст үндэслэн дараах зөвлөмжийг өгч байна.Үүнд:

Санхүү төрийн сангийн хэлтэст:

1. Төрийн сангийн үйл ажиллагааны дунд хугацааны хөгжлийн төлөвлөгөө баталж, хүний нөөц, сургалт, мэдээллийн аюулгүй байдал, дотоод хяналт, цахим шилжилтийн зорилт, шалгуур үзүүлэлтийг тусган хэрэгжүүлэх;
2. Орлого, зарлагын дансны нэгдүгээр болон хоёрдугаар гарын үсгийн эрхийг албан тушаалын тодорхойлолт, дотоод хяналтын шаардлага, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх зарчимтай уялдуулан шинэчлэн тогтоох;
3. Санхүүжилтийн эрх олголтыг батлагдсан төсвийн хуваарь, орлогын гүйцэтгэл, мөнгөн хөрөнгийн төлөвлөлттэй уялдуулж, хуваариас зөрсөн олголт бүрийн шалтгааныг баримтжуулан сар бүр нэгтгэн тайлагнах;
4. Зарцуулах эрх олгох, өөрчлөх, буцаан төвлөрүүлэх үйл явцад батлагдсан төсөв, хуваарь, гүйцэтгэл, өр төлбөрийн мэдээллийг тулган баталгаажуулах хяналтын хуудсыг мөрдүүлэх;
5. Дотоод хяналтаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийг хугацаанд нь хангуулж, хэрэгжилтийн тайланг дээд шатны байгууллагад хүргүүлэн, зөрчлийг давтан гаргасан албан тушаалтанд хариуцлага тооцуулах саналыг холбогдох байгууллагад хүргүүлж, хяналтын үр нөлөөг дээшлүүлэх;

Сумын санхүүгийн албанд:

1. Зарцуулах эрх олгох, өөрчлөх, буцаан төвлөрүүлэх үйл явцад батлагдсан төсөв, хуваарь, гүйцэтгэл, өр төлбөрийн мэдээллийг тулган баталгаажуулах хяналтын хуудсыг мөрдүүлэх.;
2. Нэмэлт санхүүжилтийн дансны зарцуулах хүсэлтийг хянаж, зарцуулах эрх олгохдоо төсвийн зориулалт, эдийн засгийн ангилал, холбогдох хууль эрх зүйн акттай нийцүүлэн шийдвэрлэх;
3. Төлбөрийн хүсэлт бүрд анхан шатны баримтын иж бүрдэл, гэрээ, нэхэмжлэх, акт, тооцоо, эдийн засгийн ангиллын зөв эсэхийг шалгах нэгдсэн жагсаалт мөрдүүлж, бүрдэл хангагдаагүй гүйлгээг буцааж хэвшүүлэх;
4. Төрийн сангийн сангийн төлбөр тооцооны баримтыг цаг тухай бүр архивлах үйл явцыг чанаржуулах ажлыг зохион байгуулж, байгууллагын архивд хүлээлгэн өгөх;
5. Эрсдэлийн үнэлгээг буцсан гүйлгээ, анхан шатны баримтын зөрчил, санхүүжилтийн саатал, архивын бүрдэл, цахим системийн доголдол зэрэг бодит мэдээлэлд үндэслэн шинэчилж, дотоод хяналтын төлөвлөгөөг эрсдэлийн түвшинтэй уялдуулах.

Үндэсний аудитын газраар уламжлуулах санал:

1. Сангийн яам, Төв төрийн санд: Засгийн газрын 2023 оны 444 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 2.6.3 дахь заалтад тусгагдсан буруу ишлэлийг засаж, орон нутгийн төрийн сангаас

санхүүжүүлэх зардлын төрөл, бүрдүүлэх баримт бичиг, хянан баталгаажуулах дарааллыг тодорхой болгох асуудлыг уламжлах;

2. Сангийн яам, Төв төрийн санд: Төрийн сангийн удирдлагын цахим системд батлагдсан төсөв, төсвийн хуваарь, зарцуулах эрх, эдийн засгийн ангилал, анхан шатны баримт, хэрэглэгчийн гарын үсгийн эрхийг автоматаар тулган хянах болон буцсан, амжилтгүй гүйлгээний шалтгааныг коджуулан тайлагнах боломж бүрдүүлэх саналыг хүргүүлэх;
3. Сангийн яам, Төв төрийн санд: Орон нутгийн төрийн сангуудад эрсдэлд суурилсан дотоод хяналт хэрэгжүүлэх, зөвлөмжийн хэрэгжилтийг цахимаар нэгтгэн хянах, давтан зөрчилд хариуцлага тооцуулах аргачлал, тайлагналын загварыг батлан мөрдүүлэх санал хүргүүлэх;
4. Төрийн албаны зөвлөл, Төрийн албаны салбар зөвлөлд: Сумын санхүүгийн албаны дарга болон төсөв, төрийн сангийн мэргэжилтний жишиг албан тушаалын тодорхойлолтыг холбогдох хууль, журам, бодит чиг үүрэг, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх зарчимтай уялдуулан шинэчлэх саналыг уламжлах;



Монгол улс, Сүхбаатар-22070 Баруун-Урт сум

7-р баг DG tower 6 давхар

Утас: +976 70518396

И-мэйл: sukhbaatar@audit.gov.mn, Вебсайт: www.audit.mn